

# ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИЛТГЭЛ 2014

Эмзэг байдлыг бууруулах, эрсдэлийг даван туулах чадварыг бий болгох замаар  
**Хүний хөгжлийн ахиц дэвшлийг бататгах нь**




**Хураангуй**



Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр© 2014  
НҮБ-ын Плаза -1, Нью-Йорк 10017, АНУ

Зохиогчийн бүх эрх хуулиар хамгаалагдсан. Урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр энэхүү илтгэлийг бүхлээр нь, эсвэл хэсэгчлэн хуулбарлах, татаж авах, электрон, механик, фото хуулбар зэрэг ямар нэгэн хэлбэрээр хувилах, хадгалах, бусдад дамжуулахыг хориглоно.



Оригинал эх бэлтгэл, хэвлэлтийг: Коммьюникэйшнс Девелопмент Инкорпорэйтэд, Вашингтон ДС, АНУ  
Дизайн болон график загварыг: Accurats.r.l, Милан, Итали

Дэлгэрэнгүй мэдээллийг <http://hdr.undp.org> цахим сайтаас харна уу.

Монгол хувилбарыг “Мөнхийн үсэг” ХХК-д хэвлэв.

# ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИЛТГЭЛИЙН БАГ 2014

## **Захирал, үндсэн зохиогч**

Халид Малик

## **Судалгаа, статистик мэдээллийн баг**

Морис Куглер (судалгааны багийн ахлагч), Милорад Ковачевич (Ахлах Статистикч), Эва Жесперсон (Дэд захирал), Субхра Бхаттачаржи, Астра Бонини, СесилияКалдерон, Алан Фукс, Эми Гайе, Саса Лучич, Артур Минсат, Шивани Нэйар, ПедроМартинс, Танни Мүкопадхияболон Хосе Пинеда

## **Мэдээлэл харилцаа, хэвлэн нийтлэлийн баг**

Уильям Орм (мэдээлэл харилцааныбагийн ахлагч), Ботагоз Абреева, Элеонор Форниер-Томбс, Анна Отрубия, Адмир Жахич, Брижитт Старк-Мэрклэйн, Саманта Уочоп,Грэйс Сэйлс

## **Хүний хөгжлийн Үндэсний илтгэлүүдийг дэмжих баг**

Жон Холл (багийн ахлагч), Кристина Хэкман, Мэри Энн Мванги

## **Үйл ажиллагаа, удирдлагын баг**

Мэндийн Сарантуяа (Үйл ажиллагаа хариуцсан менежер), Мамайе Жебретсадик, Фе-Хуарес Шанахан

# ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИЛТГЭЛ 2014

---

Эмзэг байдлыг бууруулах, эрсдэлийг даван туулах чадварыг бий болгох замаар  
**Хүний хөгжлийн ахиц дэвшлийг бататгах нь**

**Хураангуй**



НҮБ-ын  
Хөгжлийн  
Хөтөлбөр  
(НҮБХХ)

*Empowered lives.  
Resilient nations.*

*“Хүний хөгжлийн ахиц дэвшлийг бататгах нь” сэдэвт 2014 оны Хүний хөгжлийн илтгэлд Эмзэг өртөмтгий байдлыг бууруулах, эрсдэлийг даван туулах чадварыг бий болгох гэсэн өөр хоорондоо харилцан уялдаатай, хүний хөгжлийг хангахад нэн чухал ач холбогдол бүхий хоёр гол үзэл баримтлалыг авч үзэж байна.*

Анх 1990 онд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс (НҮБХХ) Дэлхийн Хүний хөгжлийн илтгэл гаргаж эхэлснээс хойш дийлэнх улс орнууд хүний хөгжилд ихээхэн дэвшил гаргаж ирлээ. Энэ жилийн илтгэл ч дэлхий нийтийн хүний хөгжлийн чиг хандлага эерэг байж, хөгжил дэвшил үргэлжилж байгааг харуулж байна. Гэсэн хэдий ч байгалийн болоод хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй гамшиг, хямралаас болж хүний амь нас үрэгдэж, амьжиргаа, хөгжил доройтсоор байна. Гэвч эдгээр сөрөг үзэгдэл нь зайлшгүй тохиолдох ёстой зүйл биш юм. Аль ч нийгэм эрсдэлд эмзэг ч аливаа аюул бэрхшээл тохиолдоход зарим хэсэг нь бусдаасаа харьцангуй бага хохирол амсч, илүү хурдан хугацаанд сэргэж байдаг. Чухам яагаад ийм байдгийг анх удаа дэлхийн Хүний хөгжлийн илтгэлд онцгойлон авч үзэж эмзэг байдал, эрсдэл бэрхшээлийг даван туулах чадавхийг хүний хөгжлийн өнцөгөөс судаллаа. Эмзэг байдлын талаар өмнө хийгдсэн олон судалгааны дийлэнх нь тодорхой зарим эрсдэлд хүмүүсийн өртөмтгий байдлыг харгалзан үзэхийн зэрэгцээ салбарын онцлогтой байх нь элбэг. Тэгвэл энэхүү Илтгэл асуудалд арай өөрөөр, илүү цогц аргаар хандсан болно. Ингэхдээ юуны түрүүнд хүний хөгжилд нөлөөлөх эрсдэлүүдийг нэмэгдүүлж буй хүчин зүйлсийг авч үзээд, улмаар эдгээр өргөн хүрээтэй өсөн нэмэгдэж буй эрсдэлийг даван туулах чадавхийг хэрхэн бэхжүүлэх арга замыг авч үзлээ.

Ийм хандлага нь өөр хоорондоо улам бүр харилцан хамааралтай болж буй эх дэлхийд маань нэн чухал билээ. Даяаршил олон ашиг тусыг авчирсан хэдий ч, өөр олон шинэ шинэ асуудлыг үүсгэж, орон

нутгийн шинжтэй хариу үйл явдлын үр нөлөө хүрээгээ тэлж өргөн олныг хамрах нь элбэг болж байна. Эмзэг бус буюу эмзэг байдал багатай ирээдүйд иргэдийг бэлдэнэ гэдэг нь хүмүүс, улс орнуудын аливаа бэрхшээлийг даван туулах бодит чадавхийг сайжруулна гэсэн үг. Энэ ажлын эх суурийг уг Илтгэл тавьж байгаа юм.

Тус илтгэл хүний хөгжлийн тухай ухагдахууныг мөрдлөг болгон хүн-төвтэй хөгжлийн хандлагыг баримталж байна. Тус илтгэл улс орны дотоодын болоод улс хоорондын ялгаатай байдалд илүүтэй анхаарч байна. Илтгэлд түүхэн хувь зохиолоор, эсвэл нийгмээс тэдэнд үзүүлж буй тэгш бус хандлагын улмаас бусдаасаа илүү эмзэг байгаа хүмүүсийг “бүтцийн хувьд эмзэг өртөмтгий” бүлэгт хамруулж судаллаа. Эдгээр эмзэг байдал нь урт удаан хугацааны туршид үүсэн бий болох бөгөөд хүйс, үндэс угсаа, уугуул байдал буюу газар зүйн байрлал зэрэг бусад олон хүчин зүйлтэй холбоотой. Эмзэг бүлгийнхэн болон бусад олон хүний дийлэнх хэсэгт аливаа хүндрэл бэрхшээлийг даван туулах чадвар харилцан адилгүй бөгөөд давхардсан олон саад тотгорууд учирдаг. Тухайлбал, ядуус, үндэсний цөөнх, эмэгтэйчүүд болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нилээдгүй саадтай нүүр тулах бөгөөд тэдгээр бэрхшээл нь бие биедээ сөргөөр нөлөөлөх нь элбэг.

Энэхүү илтгэлд эмзэг байдал бидний амьдралын явцад хэрхэн өөрчлөгддөг арга замыг “амьдралын мөчлөгийн хандлагаар” авч үзсэн байна. Бусад хөдөлгөөнгүй загваруудаас ялгаатай нь илтгэлийн судалгаа шинжилгээний үр дүн хүүхэд, өсвөр насныхан, өндөр настнууд өөр өөр онцлог эрсдэлтэй тулгарах ба тэдгээр нь тус бүртээ зохицсон хариу арга хэмжээ авахыг шаарддаг болохыг онцолж байна. Хүний амьдралын зарим үе онцгой анхаарлыг шаардах нь бий. Жишээ нь: хүүхдийн амьдралын эхний 1000 хоног, сургуулийн танхимаас ажлын талбарт шилжих, эсвэл тэтгэвэрт гарах зэрэг үеийг дурдаж болно. Эдгээр чухал үед учрах бэрхшээл, хүндрэлийг даван туулахад харьцангуй хүнд бөгөөд удаан хугацаанд нөлөө үзүүлэх магадлалтай байдаг.



Өнөөгийн байгаа нотолгоо, судалгаанд шинжилгээ хийсний үндсэн дээр энэхүү илтгэлд эмзэг байдлыг арилгасан, ирээдүйд учирч болзошгүй сорилтуудыг даван туулах чадвартай нийгэмд хүрэх хэд хэдэн чухал зөвлөмжийг санал болгож байгаа юм. Үүнд бүх нийтэд хүртээмжтэй нийгмийн суурь үйлчилгээ, ялангуяа эрүүл мэнд, боловсрол, ажилгүйдэл, даатгал, халамж, тэтгэвэр зэргийг хамруулсан нийгмийн хүчтэй хамгааллын тогтолцоо, ажил эрхлэлтийн үнэ цэнэ зөвхөн орлогын эх үүсвэрээр тогтохгүйг хүлээн зөвшөөрч ажил эрхлэлтэнд онцгой анхаарахад уриалж байгаа юм. Түүнчлэн хариуцлагатай, шударга, шуурхай ститүцийн ач холбогдлыг өргөжүүлэх, аливаа зөрчилд хүргэж болзошгүй эрсдэлийг бууруулах, нийтээрээ даван туулах чадвартай болох нэгдмэл ойлголттой байхыг чухалчилж байна. Илтгэлд өнө удаан жилд амь бөхтэй оршсоор буй эмзэг байдлыг бууруулах бодлого хичнээн үр дүнтэй байсан ч хямрал үргэлжилж, илүү хор хөнөөлтэй үр дагаврыг дагуулж болзошгүйг хүлээн зөвшөөрч, гамшигт бэлтгэлтэй байх, хүмүүс, хамт олны дунд болзошгүй сорилтыг даван туулах, нөхөн сэргээх чадварыг бий болгох нь чухал ач холбогдолтой болохыг онцолж байна. Даяаршлын түвшинд хил хязгаарыг үл харгалзах өргөн хүрээний эрсдэл нь хамтын хүч, хамтын идэвхтэй үйл ажиллагааг шаардахыг ойлгон олон улсын түвшинд засаглалыг сайжруулах, нийтээрээ хариуцлагатай байхад уриалж байна.

Эдгээр зөвлөмж нь цаг үеэ олсон бөгөөд чухал ач холбогдолтой. НҮБ-ын гишүүн орнууд 2015 оноос хойшхи хөгжлийн асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэх, тогтвортой хөгжлийн багц зорилтуудаа тодорхойлох бэлтгэл ажлын энэ үед тус Илтгэлийн суурь судалгаа, шинжилгээний үр дүн, хүний хөгжлийн хэтийн төлөв байдал онцгой үнэ цэнэтэй байна. Ядуурлыг арилгах нь, тухайлбал хөгжлийн шинэ хөтөлбөрийн цөм зорилт байх болно. Гэхдээ, Илтгэлд дурдсанчлан хэрэв хүмүүс нийгмийн

бүтцийн хүчин зүйл болоод тогтвортой оршин байгаа эмзэг байдлын улмаас ядуурал руу эргэж гулсах эрсдэлтэй хэвээр байвал хөгжлийн ахиц дэвшил эргэлзээтэй болж ирнэ. Ядуурлыг арилгах нь “тэглэх” төдий асуудал биш, цаашид ядууралгүй байхыг тогтвортой барих асуудал юм.

Улс орнуудад ядуурлыг бүх нийтээр устгах, тэгш бус байдлыг арилгах, ялгаварлал гадуурхлыг зогсоох, хүний болон тогтвортой хөгжлийг дэмжихэд нь туслах зорилго бүхий НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн чин зорилго нь эмзэг байдлыг бууруулах, сорилтуудыг даван туулах үзэл баримтлалыг онцгой анхаарахыг шаардаж байна. Эмзэг байдлыг үр дүнтэй арилгаж, иргэн бүр хөгжил дэвшилдээ ахиц гаргах боломжоор бүрэн хангагдах хүртэл хөгжил дэвшил эрх тэгш, тогтвортой байж чадахгүй.

Энэхүү Илтгэлийн гол зорилго нь шийдвэр гаргагчид болон хөгжлийн түншүүдэд эмзэг байдлыг бууруулах, сорилтуудыг даван туулах чадварыг бий болгоход чиглэсэн хөгжлийн бодлого боловсруулан, хамтран ажиллахад нь туслахад оршино. Түүнчлэн би илтгэлийг тогтвортой хөгжлийн ахиц дэвшлийг харах хүсэлтэй хэн бүгдэд, ялангуяа манай дэлхийн хамгийн эмзэг нөхцөлд байгаа хүмүүст хүргэхийг зөвлөж байна.



Хелен Кларк

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Захирагч

# 2014 ОНЫ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИЛТГЭЛИЙН АГУУЛГА

Өмнөх үг  
Талархал

## ТОЙМ

### БҮЛЭГ 1

#### Эмзэг байдал ба хүний хөгжил

Хүний хөгжлийн хэтийн төлөв  
Эмзэг хүмүүс, эмзэг дэлхий  
Сонголт башинэ боломжууд  
Бодлого, хамтын үйл ажиллагаа

### БҮЛЭГ 2

#### Хүний хөгжлийн төлөв байдал

Хүний ахиц дэвшил  
Хүний хөгжилд дэлхий нийтэд тулгарах аюул занал

### БҮЛЭГ 3

#### Эмзэг хүмүүс, эмзэг дэлхий

Амьдралын чадавхи болон мөчлөгийн эмзэг байдлууд,  
харилцан хамаарал  
Бүтцийн эмзэг байдал  
Хүчирхийлэл, аюул осолтой амьдрал

### БҮЛЭГ 4

#### Даван туулах чадварыг бий болгох нь: эрх чөлөө, хамгаалагдсан сонголт

Нийгмийн суурь үйлчилгээний түгээмэл заалт  
Амьдралын мөчлөгийн эмзэг байдлыг авч үзэх:  
цаг хугацаа хэрхэн чухал болох нь  
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих  
Нийгмийн хамгааллыг бэхжүүлэх  
Нийгмийн оролцоог авч үзэх нь  
Хямралд бэлтгэх, сэргээн босгох чадавхийг сайжруулах

### БҮЛЭГ 5

#### Ахиц дэвшлийг гүнзгийрүүлэх: Дэлхий нийтийн өмч болон хамтын үйл ажиллагаа

Үндэстэн дамнасан эмзэг байдал, түгээмэл аюул  
Даяаршсан ертөнцөд хүнийгнэн тэргүүнд тавих  
Илүү аюулгүй дэлхий ертөнцийн төлөө хамтын үйл  
ажиллагаа

Тайлбар  
Ашигласан материал

### СТАТИСТИКИЙН ХАВСРАЛТ

Уншигчдын гарын авлага  
Дэлхийн улсуудын ХХИ, зэрэглэл 2013

#### Статистикийн хүснэгтүүд:

1. Хүний хөгжлийн индекс, түүний бүрэлдэхүүн хэсэг
2. Хүний хөгжлийн индексийн чиг хандлага, 1980-2013
3. Хүний хөгжлийн индекс Тэгш бус байдлын тооцсоноор
4. Жендэрийн тэгш бус байдлын индекс
5. Жендэрийн хөгжлийн индекс
6. Олон хэмжүүрт ядуурлын индекс
- 6А. Олон хэмжүүрт ядуурлын индекс: цаг хугацаа явцын өөрчлөлт (улс орныг сонгох)
7. Эрүүл мэнд: хүүхэд, залуучууд
8. Насанд хүрэгчдийн эрүүл мэнд, эрүүл мэндийн зардал
9. Боловсрол
10. Эрх мэдэл ба эх үүсвэрийн хуваарилалт
11. Нийгмийн чадавхиуд
12. Хувь хүний аюулгүй байдал
13. Олон улсын интеграци
14. Байгаль орчин
15. Хүн амын чиг хандлага
16. Нэмэлт үзүүлэлтүүд: сайн сайхан амьдралын тухай ойлголт

Бүс нутгууд  
Статистикийн лавлагаа



Дэлхийн ихэнх улс орон, дийлэнх хүмүүс хүний хөгжлийн хувьд тасралтгүй сайжирч буй нөхцөлд амьдарч байгааг Дэлхийн Хүний Хөгжлийн удаа дараагийн Илтгэлүүд (ХХИ) амжилттай харуулсаар ирсэн. Технологи, боловсрол, орлогын ахиц дэвшил нь хүмүүст илүү урт удаан, эрүүл саруул, баталгаатай амьдралыг бий болгож байна. Гэсэн хэдий ч өнөөдөр дэлхий ертөнцөд хүмүүсийн амьжиргаа, хувь хүний аюулгүй байдал, байгаль орчин, дэлхий нийтийн улс төржилт гэх зэрэг санаа зовоох зүйлс бишгүй тулгарсаар байна. Хүний хөгжлийн тулгуур хэсгүүд болох эрүүл мэнд, хоол, хүнс тэжээлийн тал дээр олсон өндөр амжилт дэвшлийг байгалийн гамшиг, эдийн засгийн эрс уналт зэргээр амархан үгүй хийж болохоор байна. Хулгай, хүчирхийлэл ч хүнийг бие бялдар, сэтгэл санааны хувьд доройтуулж болно. Түүнчлэн авилга, хээл хахууль, хариуцлагагүй төрийн уригаар тусламж шаардлагатай хүмүүс ч амьдралын эх үүсвэргүй хоцорч мэдэхээр байна.

Хүний хөгжилд гарах бодит ахиц дэвшил нь, тэгэхээр, хүмүүст чухал сонголт хийх боломжийг өргөтгөх, боловсролтой байх чадварыг дээшлүүлэх, эрүүл амьдрах, амьжиргааны стандарт боломжийн түвшинд байх, аюул эрсдэлгүй амьдрах төдий ойлголт биш юм. Энэ нь бас эдгээр ололтууд хэрхэн баталгаатай байх, хүний хөгжлийг хангах нөхцөл хангалттай бөгөөд тогтвортой байхтай салшгүй холбоотой асуудал. Эмзэг байдлыг судалж үнэлэхгүйгээр хүний хөгжилд ахиц дэвшил гарч байгаа эсэхийг бүрэн тодорхойлох боломжгүй.

Уламжлал ёсоор, эмзэг байдлын талаарх үзэл баримтлалыг эрсдэлд өртөмтгий байдал, цочролоос хамгаалах даатгал, үндсэн хөрөнгө болон орлого ашгийг төрөлжүүлэх зэрэг эрсдэлийн менежментийг тодорхойлоход ашигладаг байсан. Тус Илтгэл нь эмзэг байдлыг

бууруулах, хүний хөгжлийг улам ахиулах зэрэг асуудал хоорондын нягт холбоонд илүү өргөнөөр анхаарах хандлага баримталаа. Хүмүүсийн чадавхи, сонголтыг доройтуулан хязгаарлаж байгаа шалтгааныг тодорхойлох зорилгоор бид эмзэг байдлын үзэл баримтлалыг судаллаа. Үзэл баримтлал талаасаа хэнийг эмзэг гэх, тэд юунд илүү өртөмтгий, яагаад гээд задалбал эмзэг байдал нь тийм ч хийсвэр ойлголт биш. (Зураг 1).

Бид ялангуяа эмзэг байдлыг бий болгож байгаа учир холбоотой, байнга орших эх үүсвэрүүд юу болохыг тодорхойлоход анхаарлаа чиглүүлсэн бөгөөд зарим хүмүүс сорилтыг даван туулахдаа яагаад бусдаасаа илүү чадвартай байдгийг онцлон судаллаа. Амьдралын мөчлөгийн янз бүрийн шатанд хүмүүс өөр өөр байдлаар эмзэг байх бөгөөд аюулд өртөмтгий чанар нь ч

## ЗУРАГ 1

Эмзэг байдалд хэн илүүтэй өртөж байна вэ? Юунд? Яагаад?



## ХҮН ТӨРӨЛХТНИЙ АХИЦ ДЭВШИЛ

2013 оны Дэлхийн Хүний хөгжлийн илтгэлд тэмдэглэснээр дэлхийн хүн амын дийлэнх хэсэг нь оршин суудаг хөгжиж буй 40 гаруй оронд Хүний Хөгжлийн Индекс (ХХИ) 1990 оны нөхцөл байдалтай уялдуулан хийсэн таамаглалаас өндөр байжээ. Гэхдээ хүний хөгжлийн бүлгүүдээр ахиц дэвшлийн түвшин ерөнхийдөө удааширч байгаа гэсэн зарим нотолгоо байгаа тул эдгээр ололт амжилтыг бүрэн баталгаатай гэхэд төвөгтэй байна.

(Зураг 2).

Олсон амжилтаа бататгах, тасралтгүй ахиж дэвшихэд тасалдал гарахаас урьдчилан сэргийлэхийн тулд эмзэг байдалтай тэмцэх нь чухал болоод байна. 2015 оноос хойшхи үйл ажиллагааны хөтөлбөр болон тогтвортой хөгжлийн зорилтуудыг боловсруулахтай уялдуулан амь бөхтэй оршсоор байгаа эмзэг байдлыг бууруулахын тулд олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө үйл ажиллагааны хэлбэрт өөрчлөлт хийх, харилцааны шинэ хэлбэрийг бий болгох цаг тулгарч, боломж ч нээгдэж байна.

Энд бас нэг чухал асуулт гарч байгаа юм. Чухамдаа бидний: хэний хөгжил цэцэглэлтийг ажиглаж байна вэ? Амьдрал сайжирч байгаа байдал нь хувь хүмүүс, хамт олон, улс үндэстний хувьд хэрхэн хуваарилагдаж буй талаар илүү цогц ойлголт авахын тулд орлогын дундаж болон доод босгоноос илүү ихийг харах шаардлагатай. Сүүлийн жилүүдэд ихэнх бүс нутагт тэгш бус байдлаас шалтгаалсан хүний хөгжлийн түвшний бууралтын дундаж хэмжээ багасахад эрүүл мэндийн ололтууд голлон нөлөөлсөн байна. Гэвч хэд хэдэн бүс нутагт орлогын ялгаа нэмэгдэж, боловсролын тэгш бус байдал хэвээрээ байна. Тэгш бус байдал багасч байгаа нь олзүүрхүүштай ч орлогын ялгааны бууралт болон эрүүл мэндийн нөхцөл хангалтгүй байна. Ялангуяа тодорхой бүлгүүдийн хувьд эмзэг байдлыг арилгах, олсон амжилтуудаа тогтворжуулахын тулд, хүний хөгжлийн бүхий л үзүүлэлтүүдэд нөлөөлж байгаа тэгш бус байдлыг бууруулах нь маш чухал болж байна.

ялгаатай байна. Хүүхэд, өсвөр насныхан болон өндөр настнууд илүү эмзэг байх учир тэдний амьдралын шилжилтийн үе шатанд хөндлөнгийн ямар оролцоо, ямар дэмжлэг, хөрөнгө оруулалт эмзэг байдлыг бууруулж болохыг авч үзэх нь нэн чухал байлаа.

Илтгэлд хувь хүн болон нийгмийн чадавхийг тогтвортой сайжруулах нь амь бөхтэй оршсоор байгаа эмзэг байдлыг бууруулахад хэрэгтэй гэдгийг онцлоод эдгээр эмзэг байдал нь бүтцийн гаралтай, мөн амьдралын мөчлөгт холбоотой болохыг тодорхойлж байна. Ахиц дэвшил нь даван туулах чадвартай, тэсвэрлэг хүний хөгжлийг хангах асуудал юм. Тэсвэр буюу даван туулах чадварын тухай ойлголтын талаар ихээхэн маргалддаг.

Гэвч бидний анхаарал хүмүүний тэсвэр, даван туулах чадварт төвлөрч байгаа ба хүмүүсийг сонголтоо одоо ч, ирээдүйд ч зөв хийж, аливаа бэрхшээлтэй үзэгдлүүд, тааламжгүй нөхцөл байдлыг сөрөх, давж гарах чадвартай болгох нь чухал юм.


Байгууллага, бүтэц, хэм хэмжээ нь хүний даван туулах чадварыг сайжруулж, бас эсрэгээр, бууруулж чадна. Төрийн бодлого болон олон нийтийг дэмжих сүлжээ нь аюул гамшиг бий болох үед, бий болох газар нь түүнийг даван туулахад нь хүмүүст туслахын зэрэгцээ, хэвтээ тэнхлэгт бүх нийтийн тэгш бус байдал нь тодорхой бүлэг хүмүүсийн дасан зохицох, даван туулах чадварыг сулруулдаг.

Илтгэлд даван туулах чадварыг бий болгож нийгмийн бүтээгдэхүүн болгодог, ялангуяа нийгмээс гадуурхагдсан бүлгүүдэд, амьдралын эгзэгтэй цаг үед нь тусалдаг төрийн бодлого, бүтцийн шинэчлэл дүн шинжилгээ хийж, ялгаварлан гадуурхах явдлыг устгах бүх нийтийн үйл ажиллагааг үнэлж цэгнэхийн хамт тухайн улс үндэстний төрийн байгууллагуудын хойрго байдал, дэлхий нийтийн засаглалын хомсдолоос үүдэлтэй эмзэг байдлыг шийдвэрлэх хамтын ажиллагааны хэрэгцээнд анхаарлаа хандуулж байна.

Эмзэг байдал хүний хөгжилд сөргөөр нөлөөлөх бөгөөд бодлого, нийгмийн хэм хэмжээг өөрчлөх замаар, системтэйгээр шийдэхгүй бол ахиц дэвшил нь адил тэгш, тогтвортой байж чадахгүй.

## ЗУРАГ 2

Хүний хөгжлийн түвшнийг илэрхийлэх бүх дөрвөн бүлгийн хувьд Хүний Хөгжлийн Индексийн өсөлтийн эрч буурсан байна



Тайлбар: Хөгжингүй болон хөгжиж буй 141 улс орны хувьд харьцуулсан хүн амын жигнэсэн дундаж  
Эх сурвалж: Хүний Хөгжлийн Илтгэлийн алба

### ЭМЗЭГ ХҮМҮҮС, ЭМЗЭГ ДЭЛХИЙ


Ядуурлын туйл, үгүйрэл хоосролд нэрвэгдэн амьдарч байгаа хүмүүс хамгийн эмзэгттооцогдож байна. Сүүлийн жилүүдэд ядуурлыг бууруулах талаар ихээхэн ахиц дэвшил гарч байгаа хэдий ч дэлхий дээр 2.2 тэрбум гаруй хүн олон хүчин зүйлээс шалтгаалсан ядуурлын туйлд түн ойрхон амьдарч байна (Зураг 3). Энэ нь манай дэлхийн хүн амын 15 орчим хувь нь олон хүчин зүйлээс шалтгаалсан ядуурлын түвшинд амьдарч байна гэсэн үг. Үүний зэрэгцээ дэлхийн нийт хүн амын 80 орчим хувьд нь нийгмийн иж бүрэн хамгаалалт дутагдаж байна. Түүнчлэн 12 хувь нь (842 сая хүн) урхагшсан өлсгөлөнгөөр шаналж, хөдөлмөрийн насны хүн амын тал хувь нь буюу 1.5 тэрбум нь албан бус буюу эрсдэлтэй, найдваргүй ажил эрхэлж байна. Боловсрол, эрүүл мэнд зэрэг үндсэн мэдлэг чадавхи нь хязгаарлагдмал

хүмүүс өөртөө тохирсон бүрэн дүүрэн амьдралаар амьдарч чадахгүй байна. Тиймээс тэдний амьдралын сонголт ч нийгмийн саад тотгор, бусад шалтгаанаас болоод хязгаарлагдаж байгаа юм. Чадавхи нь сул, хязгаарлагдмал сонголттой хүмүүс аливаа саад тотгор, бэрхшээлийг даван туулж, дасан зохицож чадахгүй болдог. Амьдралын мөчлөгийн хэрэгцээ шаардлагатай үед нь хангалттай хөрөнгө оруулалт хийгдээгүй, шаардлагатай цагт нь анхаарал тавиагүйн улмаас хүмүүсийн чадавхи нь хязгаарлагдаж, улмаар тэдний эмзэг байдлыг бий болгон хуримтлуулж хурцатгана. Аливаа цочрол, сорилт бэрхшээлийг хэрхэн даван туулах талаарх нөхцлийг бүрдүүлдэг хүчин зүйлсэд төрсөн нөхцөл байдал, нас, ялгагдах шинж байдал, нийгэм-эдийн засгийн статус зэрэг хувь хүн өөрөө хянах боломж багатай буюу огт боломжгүй хүчин зүйлс ордог.

Амьдралын мөчлөгийн эмзэг байдал, бүтцийн эмзэг байдал, аюулгүй байдлаар хангагдаагүй амьдрал зэрэг нь бөх голтой оршоор байгаа доройтлын эх үүсвэр болдог. Хүний хөгжлийг баталгаажуулж, ахиц дэвшлийг тогтворжуулахад эдгээр асуудлыг шийдэх ёстой.

### ЗУРАГ 3

1.2 тэрбум орчим хүн өдөрт \$1.25-оос бага мөнгөөр амь зогоож, 1.5 тэрбум хүн ядуурлын түвшинд амьдарч байна.



Эх сурвалж: Олон хэмжүүрт ядуурал, өрхийн янз бүрийн судалгаанд үндэслэсэн Хүний Хөгжлийн Илтгэлийн Албаны тооцоолол, ICF Макро Хүн ам болон Эрүүл мэндийн судалгаа, НҮБ-ын Хүүхдийн сангийн Олон үзүүлэлттэй бүлгийн түүвэр судалгаа, хэд хэдэн үндэсний хэмжээний өрхийн судалгаанууд, орлогын ядуурал, Дэлхийн Банкны Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүдийн мэдээллийн санд тулгуурласан Хүний хөгжлийн Илтгэлийн Албаны тооцоолол.

### АМЬДРАЛЫН ТҮРШИД ТОХИОЛДОХ ЭМЗЭГ БАЙДАЛ

Чадавхи нь хүний амьдралын түршид бий болох бөгөөд улмаар төлөвшиж, тасралтгүй сайжирч байх ёстой, эс тэгвээс зогсонги байдалд орно. Ихэнх хүмүүсийн эмзэг байдал нь (давуу тал нь ч мөн адил) (хуримтлагдаж ирсэн) амьдралын түршлага, аливааг даван түүлах, дасан зохицох арга замыг багтаасан тэдний амьдралын түүхийн үр дүн юм. Амьдралын чадавхи үндсэн хоёр замаар бүрэлдэн тогтдог байна. Юуны түрүүн, хүний насны аль ч үе дэх чадавхи нь өмнөх үед оруулсан хөрөнгө оруулалтын үр өгөөж бөгөөд тэдний амьдран буй орчин, хамт олон, нийгмийн харилцан хамаарлын нөлөөнд байдаг. Удаах нь ихэнхдээ урт


хугацааны турш үр дагавар нь үргэлжилж мэдэх гэнэтийн цочрол сорилт байдаг. Хувь хүмүүс ихэвчлэн шилжилтийн гэж нэрлэгддэг гэнэтийн цочролоос өөрийгөө зайлуулж тэр болгон чаддаггүй. Зарим нэгэн үр нөлөөг эргүүлж болох ч тэр болгон боломж гардаггүй, энэ нь тухайн нөхцөлөөс шалтгаалахын зэрэгцээ өртөг өндөртэй байх магадлалтай.

Амьдралын чадавхид оруулах хөрөнгийг аль болох эрт хийх тусам ирээдүйн төлөв нь сайн байна. (Зураг 4 дээрх тод цэнхэр шугамыг харна уу). Эсрэгээр томъёолж ч бас болно -Амьдралын чадавхийг дэмжихэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг тухайн цагт нь үргэлжлүүлэн хийгээгүйгээс тухайн хүн хүний хөгжлийн боломжуудыг бүрэн



## ЗУРАГ 4

Амьдралын чадвархид хөрөнгө оруулалтыг эрт хийх тусам ирээдүйн төлөв нь илүү сайн байна



Эх сурвалж: Хүний хөгжлийн илтгэлийн албаны тооцоолол

дүүрэн ашиглаж чадахгүйд хүрнэ. (Зураг 4 дээрх тод улаан шугамыг харна үү). Хожим хийгдсэн хөрөнгө оруулалт нь хүмүүст алдсан боломжийг эргүүлэн нөхөж (гэхдээ ихэвчлэн бүрэн бус, хэсэгчлэн), цаашид хүний хөгжил ахиц дэвшил гаргах бололцоо олгоно. (Зураг 4 дээрх тасархай цэнхэр шугамыг харна үү).

Ядуурал нь бага насны хүүхдийн хэвийн хөгжлийг алдагдуулах гол шалтгаан болох нь түгээмэл байна. Хөгжиж буй орнуудад таван хүүхдийн нэг нь туйлын ядуу нөхцөлд байгаагаас тэд хоол тэжээлийн дутагдалд орох эрсдэл ихтэй байна. Нийт хүүхдийн 92 хувь нь амьдарч байгаа хөгжиж буй улс оронд 100 хүүхэд тутмын долоо нь таван нас хүрэхгүй эндэж байна. Мөн тавь нь төрсний бүртгэлгүй, 68 нь бага насандаа боловсрол олж авч чадахгүй, 17 нь бага сургуульд огт орж чаддаггүй, 30 нь хөгжлийн хоцрогдолтой, 25 нь ядуурлын нөхцөлд амьдарч байна. Хоол хүнсний хангалтгүй байдал, ариун цэврийн байгууламжийн эрүүл ахуйн нөхцөл мүү зэргээс болж элдэв халдвар болон өсөлтийн хоцрогдлын эрсдэл өндөр байна. Халдварт өвчин, хоол тэжээлийн


дутагдлаас болж 156 сая шахам хүүхэд өсөлтийн хоцрогдолтой байна.

Нас баралтын 35 хувийг улаан бурхан, хумхаа, уушгины хатгалгаа болон сүүлгалт эзэлж байгаад ч хоол тэжээлийн дутагдал нөлөөлж байна. Ийнхүү дутагдал, хомсдол хүүхдийн бага балчир насанд буюу эрт тохиолдох тусам цаашдын эрсдэл өндөр байна.

Наад захын шаардлагатай хоол тэжээлийн дутагдал, эрүүл мэндийн түслэмж болон эрүүл өсөлтийг хангах дэмжлэг хомс байгаагаас олон ядуу хүүхэд сургуульд орохдоо сурч боловсроход бэлэн биш, үүнээс болж амжилтгүй суралцаж, анги улирч байна. Мөн хүүхэд сургуулиас завсардах магадлал өндөр байна. Бүр зургаан настайдаа буюу сургуульд орох насандаа л ядуу хүүхэд аль хэдийнэ сул тал ихтэй болж байна. (Зураг 5). Мэдлэг чадварын хувьд ч ялгаа эрт үүсч байна. Жишээ нь, үг сонгон цуглуулж ярих чадвар хүүхдийн эрт насанд эхэлдэг. АНУ-д 36 сартай хүүхдийн хэл ярианы чадвар нийгэм, эдийн засгийн янз бүрийн бүлэгт эрс ялгаатай байгаа ба хэл ярианы чадварын энэхүү ялгаа нь 9 насанд нь ч

## ЗУРАГ 5

Хожим хийгдсэн хөрөнгө оруулалт хүмүүст алдсан боломжийг нөхөж хүний хөгжлийн замаар өндөр амжилт олж болохыг харуулна.



Эх сурвалж: Paxson болон Schady 2007.

хэвээр байсаар байна. Иймд цагаа олсон хөрөнгө оруулалт, тухайлбал бага насны боловсролд оруулах хөрөнгийг цаг тухайд нь хийх зэрэг асуудал маш чухал юм.

Өсвөр залуу нас буюу 15-24 насны үе нь хүүхдүүд нийгэмтэй, ажил хөдөлмөрийн ертөнцтэй харьцаж, харилцаж сурах шилжилтийн гол үе юм. Олон оронд залуучуудын тоо нэмэгдсээр байна. Ажлын арга түршлага бага, нийгмийн сүлжээ, харилцаа холбоо өргөн биш, ажил хайх чадвар дутмаг, ажилтай болох санхүүгийн эх үүсвэрийн хомсдол зэргээс шалтгаалан дэлхий даяар хөдөлмөрийн зах зээл дээр залуучууд гологдох эрсдэл өндөр байна. Тиймээс тэд ажилгүй байх, буюу орон тооны бус, эсвэл бага цалинтай ажилтай байх, тогтмол бус гэрээт ажилтай байх магадлал өндөр байна. 2012 оны байдлаар дэлхийн залуучуудын ажилгүйдлийн түвшин ойролцоогоор 12.7 хувь буюу насанд хүрэгсдээс бараг гурав дахин өндөр байжээ.

Хөдөлмөрийн зах зээл дээрх залуусын хүлээлтийг биелүүлэхийн тулд зоримог бодлого явуулах шаардлагатай байна. “Зоримог бодлого” хувилбарын хүрээнд хөдөлмөрийн зах зээлд цөөн тооны хүүхэд залуусыг оруулах болон эдийн

засгийн өндөр өсөлт гэсэн хосолсон арга хэмжээний үр дүнд залуучуудын дундах ажилгүйдлийн түвшинг 2050 он гэхэд 5 хувиас бага байлгахыг зорино. Гэвч, бүс нутгийн шинжтэй өөр хувилбарууд байсаар байна.


“Ердийн бизнес” хувилбараар бол энэ ялгаа ялангуяа Сахарын Африкт нэмэгдэх хандлагатай байх боловч зоримог бодлогууд (боловсролыг шуурхай нөхөн олгох бодлого болон эдийн засгийн түргэвчилсэн өсөлт)-ын үр дүнд залуу ажилчдын эрэлт нийлүүлэлтийн зөрүүг Өмнөд Азийн хувьд арилгаж, Сахарын Африкийн хувьд багасгах болно (Зураг 6). Өмнөд Азид 2050 он гэхэд энэхүү зөрүүг (хөдөлмөрийн зах зээлд шилжиж буй залуу ажилчдын тоог бууруулах) хүн ам зүйн өөрчлөлтөд суурилсан боловсролын талаарх бодлого болон эдийн засгийн эрчтэй өсөлтийн хосолсон нөлөөгөөр арилгах ба Сахарын Африкийн хувьд зөрүүг бүрэн арилгахын тулд өсөлтийг хангахуйц хөдөлмөр эрхлэлтийг эрчимжүүлсэн нэмэлт бодлого шаардлагатай.

Ядуурал болон нийгмээс гадуурхагдах явдал өндөр настнуудын дунд ч бас асуудал хэвээр байна. Учир нь манай гарагийн өндөр настан хүн амын бараг



## ЗУРАГ 6

Боловсролыг шуурхай нөхөн олгох бодлого ба эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх бодлого нь 2010-2050 оны хооронд Өмнөд Азийн орнуудад залуу ажилчдын эрэлт нийлүүлэлтийн ялгааг арилгаж Сахарын Африкт багасгана.



Эх сурвалж: Хүний хөгжлийн тайлан газар тооцоо Лутц болон Кё (2013), Олон улсын Futures (2013)-ийн Pardee төв дээр суурилсан.

80 орчим хувь нь тэтгэвэр авдаггүй бөгөөд орлогын хувьд ажил, аль эсвэл гэр бүлдээ л найддаг байна. Иймээс нас нь өндөр болохын хэрээр хүмүүс бие бялдар, сэтгэл зүй, эдийн засгийн хувьд илүү эмзэг болж байна. Залуу насандаа эдийн засгийн боломж, аюулгүй байдлаар хомс байсан хүмүүсийн хувьд эдгээр нь хуримтлагдсаар эмзэг байдалд хүргэдэг тул хүмүүс өтлөхийн хэрээр ядууралд өртөх үзэгдэл архагшиж байна. Ингэж залуу наснаас хуримтлагдсан сул тал буюу эмзэг байдал ядуурлыг нэг үеэс нөгөөд дамжуулж байгаа юм.

### ТОГТОЛЦООНЫ ЭМЗЭГ БАЙДАЛ

Нийгмийн болон эрх зүйн байгууллагууд, хүчний байгууллагын тогтолцоо, улс төрийн орон зай, аль эсвэл уламжлал, нийгэм соёлын хэм хэмжээ зэрэг нь гишүүддээ ижил үйлчлэхгүй байх явдал түгээмэл байна. Ингэснээр зарим хүмүүс болон нийгмийн бүлгүүдэд эрхээ эдэлж сонголт хийхэд нь тогтолцооноос үүдсэн саад бэрхшээл үүсгэж байна. Энэ нь тогтолцооноос үүдсэн эмзэг байдал

болно. Тогтолцооноос үүдсэн эмзэг байдал нь нийгэм дэх гүн гүнзгий тэгш бус байдал, хавтгайрсан ядуурлаар илэрдэг бөгөөд нийтээрээ хүлээн зөвшөөрсөн, хэсэг бүлэг хүмүүсийн гишүүнчлэлд суурилсан горизонтал буюу нийтийн тэгш бус байдалтай хамааралтай. Ядуус, эмэгтэйчүүд, цөөнхүүд (үндэсний, хэлний, шашны, шилжин суурьшигчид, цагаач эсвэл бэлгийн), уугуул оршин суугчид, хөдөөгийн, алслагдсан орон нутгийн иргэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, мөн далайд гарцгүй буюу хязгаарлагдмал байгалийн нөөцтэй улс орнууд чадавхи бий болгох, дэмжлэг авах эрхээ эдлэх, сонголт хийх тал дээр, гэнэтийн цочрол, гамшгийн үед хамгаалалт авах, мөн зарим үед хууль эрх зүйн шинж чанартай саад бэрхшээлтэй тулгарах нь харьцангуй түгээмэл.

Тулгарч буй тогтолцооноос үүдсэн эмзэг байдлын эрсдэл нь урт удаан хугацааны туршид хүйсийн, үндэс угсааны болон арьсны өнг, эрхэлж буй ажлын төрөл, нийгмийн байдал зэргээс хамааран эрсдэлийг даван туулахад хүндрэлтэй ялгаа үүсгэж байна.

Тогтолцооноос үүдсэн эмзэг байдалд байгаа хүмүүс бусадтай адилхан чадавхитай байж болох хэдий ч гэнэтийн эрсдэлтэй нөхцөл байдалыг давантуулахад илүү их бэрхшээлтэй тулгарч мэднэ. Жишээ нь, хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийтийн тээвэр, төр засгийн байгууллагууд болон эмнэлэг зэрэг олон нийтийн газарт үйлчлүүлэх нэвтрэх боломжоор хомс байдаг нь тэдний эдийн засаг, нийгэм, улс төрийн амьдралд оролцох оролцоог, эсвэл амь нас, эрүүл мэндэд аливаа аюул занал тулгарсан үед туслалцаа хайх боломжийг илүү хүндрэлтэй болгодог.

Олон хүн, жишээ нь, ядуус, цөөнхийн бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд эрсдэл бэрхшээлийг даван туулах чадавхийн хувьд тогтолцооноос үүдсэн давхардсан олон саад тотгортой тулгарч байна. Дэлхийн нийт ядуу хүмүүсийн дөрөвний гурав нь хөдөө орон нутагт, ялангуяа ядууралд хамгийн ихээр өртдөг хөдөө аж ахуй, газар тариалангийн бүс нутагт амьдарч байна. Тэд бүтээмж багатай, уян хатан бус, бага цалин хөлстэй хөдөлмөр эрхэлж, улирлын чанартай ажилгүйдэл, цаг уурын таагүй нөхцөлд нэрвэгдэх нь элбэг байдаг. Иргэний болон сонгуулийн эрх нь хязгаарлагдмал үндэстний болон шашны цөөнхүүд нь ялгаварлан гадуурхах явдал, хэлмэгдүүлэлтэнд өртөмтгий, албан ёсны хууль эрх зүйн системийн үйлчилгээнээс ангид буюу хязгаарлагдмал байна. Хэдийгээр нутгийн уугуул оршин суугчид дэлхийн нийт хүн амын таван хувийг эзэлдэг ч тэд дэлхийн ядуу хүн амын 15 орчим хувийг бүрдүүлж, гуравны нэг нь туйлын ядуу нөхцөлд амьдарч байна. Манай гарагийн 60 ба түүнээс дээш настай хүн амын 46 хувь нь хөгжлийн бүрхшээлтэй амьдардаг бөгөөд тэдэнд нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцоход ихээхэн бэрхшээлтэй тулгарч, улмаар нийгмийн ялгаварлан гадуурхах хандлагад өртөх эрсдэлтэй байна.

#### **ХЭСЭГ БҮЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ БА ХАМГААЛАГДААГҮЙ АМЬДРАЛ**

Аливаа зөрчил болон хувь хүний аюулгүй байдал алдагдаж буй мэдрэмжтөрөх нь хүний хөгжилд сөрөг нөлөө үзүүлдэг төдийгүй сая сая хүнийг

амьдралын эрсдэлтэй нөхцөл байдалд оруулж байна. Хүний хөгжлийн индексийн үзүүлэлтээр хамгийн доогуур байгаа олон улс орон удаан хугацааны туршид дотоодын зөрчилтэй буюу сөргөлдөгч талуудын зэвсэгт мөргөлдөөний хүчирхийлэлтэй нөхцөлд оршин тогтнож байгаа бөгөөд 1.5 сая гаруй хүн буюу дэлхийн хүн амын тавны нэг орчим нь ийм зөрчилдөөний нөлөөнд өртсөөр байна. Саяхны улс төрийн тогтворгүй байдал ч хүн амын хувьд хүчтэй хохирол учруулж, 2012 оны эцсийн байдлаар зөрчил мөргөлдөөний улмаас 45 сая хүнийг оршин суугаа газраа хүчээр орхиход хүргэсэн бөгөөд үүний 15 сая гаруй нь дүрвэгсэд байгаа нь сүүлийн 18 жилийн хувьд хамгийн өндөр үзүүлэлт юм. Төв болон Баруун Африкийн зарим бүс нутагт үргэлжилсээр байгаа эмх замбараагүй, хууль бус байдал, зэвсэгт мөргөлдөөн нь хүний хөгжилд аюул занал учруулж, үндэсний хөгжлийн ахиц дэвшилд сөргөөр нөлөөлж байна. Латин Америк болон Карибын тэнгисийн зарим оронд хүний хөгжлийн ололт амжилт гарч байгаа хэдий олон хүн өсөн нэмэгдсээр байгаа гэмт хэрэг, хүчирхийллийн золиос болох айдастай амьдарч байна.

#### **ЭРСДЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ ЧАДВАРЫГ БИЙ БОЛГОХ НЬ**

Хүмүүсийн сайн сайхан амьдрал нь тэдний амьдралын эрх чөлөөний хэм хэмжээгээр тодорхойлогдох бөгөөд байгалийн ба хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй осол гамшгийг сөрөх, давах чадавхиас нилээд хамааралтай. Эрсдэлийг даван туулах чадавхи гэдэгт хүний хөгжлийг баталгаажуулах, тогтворжуулах аливаа оролдлого, арга замыг ойлгож болно. Үүний гол цөм нь хүмүүсийг хамгаалах, чадавхижуулах талаарх улс орнуудын төр засаг, олон нийт улмаар дэлхий дахины байгууллагуудын хамтын ажиллагааг хангах асуудал юм. Хүний хөгжил нь хүнийг аливаа үйлдэл хийх эрх чөлөөгөө эдлэхэд учирч байгаа саад бэрхшээлийг арилгах, ялангуяа, гадуурхагдсан, тусгай хэрэгцээтэй хүмүүст эрхээ эдлэх, бэрхшээлээ нээлттэй илэрхийлэх, үгээ хэлэх, бусдад ойлгогдох, өөрийн хувь заяаныхаа идэвхтэй хөтөч байх чадавхитай

Эмзэг байдлыг бууруулах бодлогын үйл ажиллагаа хүмүүсийн чадавхийг дэмжих, хамгаалах, ялангуяа хамгийн эмзэг хэсэгт чиглэх шаардлагатай байна.

## Зарчим ба бодлого

Хүний хөгжлийг хангах, амьдралын тэгш боломж олгох үзэл санаан дээр тулгуурлан эмзэг байдлыг бууруулах, эрсдэлийг даван туулах чадавхийг сайжруулахад чиглэсэн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд туслах дөрвөн гол зарчмыг бид дэвшүүлж байна

## Бүх нийтээр нь анхааралдаа авах

Хүн бүр адил тэгш үнэ цэнэтэй бөгөөд хамгаалуулах, дэмжлэг авах эрхтэй. Тиймээс эрсдэл, аюул заналд хамгийн их өртөж байгаа хүмүүс, хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд бүгдийн адил тэгш амьдралын боломжтой байхын тулд тусгайлсан нэмэгдэл тусламж шаардлагатайг хүлээн зөвшөөрөх ёстой.

Түгээмэл байдал нь тэгэхээр тэгш бус анхаарал, халамжийг шаардана гэсэн үг. Бүх хүмүүсийг адил тэгш авч үзэхийн тулд сул дорой заримд нь илүү анхаарах нь зүйтэй.<sup>1</sup>

## Хүнийг эн тэргүүнд тавих

1990-д оноос эхлэн Дэлхийн хүний хөгжлийн илтгэлүүдээр удаа дараалан гаргаж тавьсаар ирсэн хүний хөгжлийн “Хүнийг эн тэргүүнд тавих” гэсэн үндсэн санааг илүү тодотгон эмзэг байдлыг бууруулах нь хүний хөгжилд нэн чухал болохыг энэхүү илтгэлээр уриалж байна. Төрийн бүхий л бодлогууд, ялангуяа макро эдийн засгийн бодлогууд энэ зорилгод хүрэх хэрэгсэл болох бөгөөд бодлого боловсруулагчдын өмнө олон чухал асуудал гарч ирж байна. Эдийн засгийн өсөлт нь хүмүүсийн амьдралыг ялангуяа тэдний хамгийн гол хэрэгцээ болох боловсрол, эрүүл мэнд, орлогоос эхлээд хүний аюулгүй байдал, хувь хүний эрх чөлөөг хангах асуудлыг сайжруулж чадаж байгаа эсэх? Хүмүүс эмзэг байгаагаа илүү ихээр мэдэрч, зарим хэсэг нь анхаарлын гадна орхигдож байна уу? Хэрэв тийм бол хүн амын ямар хэсгийг хамарч байна вэ? Эмзэг, тэгш бус байдлыг хэрхэн арилгах вэ? гэх мэт.

## Хамтын үйл ажиллагаанд оролцох

Өнөөгийн тулгамдсан асуудлуудыг шийдэхэд хамтын үйл ажиллагаа нэн чухал байна. Хүмүүс нягт хамтарч ажиллах үедээ л өөрсдийн хүч чадлаа нэгтгэн аливаа аюулыг сөрөх сонголтоо зөв хийж чадах бөгөөд тэдний ийм нэгдмэл эрсдэлийг даван туулах чадавхи нь хөгжил дэвшлийг ахиулж улам илүү тогтвортой болгоно. Улс орнуудын хувьд ч мөн адил хүчээ нэгтгэн хил дамнанас аюул занал, эмзэг байдлыг бууруулахын тулд дэлхий нийтийн хэрэгцээг хангах бараа бүтээгдэхүүн нийлүүлэх шаардлагатай байна. Бидний эргэн тойронд маш олон тодорхой бус зүйл байгаа хэдий ч нэг л зүйл маш тодорхой. Энэ нь нийтийн эрх ашиг, хүртээмжийн талаар алсыг эерэгээр харах нь үндэсний болон дэлхийн хүн амын нийтлэг эрх ашигт нийцсэн бараа бүтээгдэхүүнээр хэр амжилттай хангахаас ихээхэн хэмжээгээр хамаарна.

## Улс орнууд, нийгмийн байгууллагууд хоорондын үйл ажиллагааг зохицуулах

Хувь хүмүүс дангаараа хөгжих боломжгүй. Үнэндээ, тэд дангаараа юуг ч бүтээж чадахгүй. Хүнийг төрөх үед гэр бүл нь тэжээн тэтгэж байдаг. Үүнтэй нэгэн адил гэр бүл ч нийгмээсээ ангид бие даан оршиж чадахгүй. Нийгмийн хэм хэмжээг боловсронгуй болгох бодлого, нийгмийн нэгдэл, чадавхи нь төр, засгийн газрууд болон нийгмийн байгууллагуудын эмзэг байдлыг бууруулах талаарх нягт хамтын ажиллагаанд чухал үүрэгтэй болно.

Зах зээл болон тогтолцооноос шалтгаалсан эмзэг байдал бий болж буй тохиолдолд засгийн газрууд, нийгмийн байгууллагууд зах зээлийг удирдаж эмзэг байдлыг хязгаарлах шаардлагатай бөгөөд зах зээлийн жамаар хийгдэх боломжгүй тохиолдолд хүмүүст туслах шаардлагатай байна.

Тайлбар


1.Sep. 1992

болгох явдал бөгөөд хэн боловч үнэ цэнэтэй бүрэн дүүрэн амьдралаар амьдрах, үйл хэргээ зохистой хөтлөн явуулах эрх чөлөөгөөр хангах асуудал юм. Илтгэлд эрсдэлийг даван туулах чадавхи бий болгоход шаардагдах зарим гол бодлогын зарчим, түүний хэмжүүр

болох сонголтыг өргөжүүлэх, хүний эрхийг дээдлэх, нийгмийн чадамжийг дэмжихийг онцлон авч үзсэн бөгөөд (Шигтгээ 1) хүний хөгжлийн ахиц дэвшлийг хангах, улмаар бататгах нь гэнэтийн цочрол үйл явдалд бэлэн байх, хариу үйлдэл хийх чадавхиас шалтгаалдаг болохыг харуулж байна.

## ЗУРАГ 7

Хэд хэдэн улс орон нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ нь Өмнөд Азийн ихэнх орнуудын өнөөдрийн дунджаас бага байх үедээ нийгмийн даатгалын арга хэмжээг авч эхэлжээ



Эх сурвалж: Maddison (2010) дээр суурилсан тооцоо.

Хүн бүр сурч боловсрох, эрүүл мэндийн тусламж болон бусад суурь үйлчилгээг авах эрхтэй байх ёстой. Энэхүү түгээмэл зарчмыг амьдралд, ялангуяа ядуус болон бусад эмзэг бүлгийн төлөө хэрэгжүүлэх нь онцгой анхаарал, халамж, эх үүсвэр шаардана.

### БҮХ НИЙТИЙН НИЙГМИЙН СУУРЬ ҮЙЛЧИЛГЭЭНИЙН ХАНГАМЖ


Бүх нийтийг нийгмийн суурь үйлчилгээгээр хангах нь суурь чадавхиудыг бий болгох асуудал бөгөөд бүх нийтэд хүртээмжтэй адил тэгш байх явдал юм. Бүх нийтийн нийгмийн суурь үйлчилгээ болох боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, ундны усны хангамж, ариун цэвэр эрүүл ахуй болон олон нийтийн аюулгүй байдал зэрэг нь бүх хүнийг үнэ цэнэтэй бүрэн дүүрэн амьдралаар амьдруулахын тулд хүн бүрт адил тэгш хүртээмжтэй хангагдсан байхын зэрэгцээ сайхан амьдралын үндэс болсон эдгээр үйлчилгээ хувь хүний төлбөрийн чадвараас хамааралгүй байх ёстой. Нийгмийн суурь үйлчилгээг бүх нийтэд хүргэх асуудлыг хөгжлийн эхний үед ч шийдэж болно (Зураг 7).

Түүнчлэн үүнийг маш хурдан хугацаанд (арван жилийн дотор) хийж

болохыг Бүгд Найрамдах Хятад Улс, Руанда болон Вьетнам улсын саяхны туршлага харуулж байна. Бүх нийтийг нийгмийн суурь үйлчилгээгээр хангаснаар нийгмийн чадавхийг дээшлүүлж, эмзэг байдлыг бууруулж чадна. Тэрээр боломж болон үр дүнг тэнцэтгэх хүчирхэг хэрэгсэл болно. Тухайлбал, бүх нийтийн чанартай боловсролын тогтолцоо нь баян, ядуу айл өрхийн хүүхдүүдийн боловсролын түвшний ялгааг бууруулах боломж олгоно. Гэр бүлийн гишүүдийн боловсрол гэх мэт чадавхийг үеэс үед дамжуулан өвлүүлснээр удаан хугацааны турш дахь давуу байдлыг бий болгоно. Бүх нийтийг хамарсан төр засгийн сайн бодлого нь үйлчилгээг хүртэгчдийг ялгаварлан гадуурхах, үзүүлж буй үйлчилгээний чанарт ялгаа гаргах, эмзэг бүлгийнхэнд шилжихгүй байх зэрэг нийгмийн гүтэмшиг болсон султалуудаас зайлсхийж, нийгмийн эв нэгдлийг бий болгоход тусална.

## ЗУРАГ 8

Нас ахих тусам нэмэгдэх эрүүл мэнд, боловсрол, болон бусад халамжийн зардал хүний насны эрт үед нь буюу хүүхэд ахуйд нь чадавхийг хөгжүүлэхэд дэмжлэг болж чадахгүй байна.



Эх сурвалж: Karoly болон бусад 1997.

Нийтлэг болсон нэгэн буруу ойлголт бол зөвхөн чинээлэг улс орнууд л нийгмийн хамгаалал буюу бүх нийтэд зориулсан суурь үйлчилгээг бий болгож чадна гэх үзэл юм. Илтгэлийн суурь судалгаа, тооцоолол үүнийг эсрэг болохыг нотолж байна. Дотоодын хүчтэй үймээн самуун, зэвсэгт хүчирхийлэлд өртсөн орнуудаас бусад ихэнх улс орнууд нийгмийн хамгаалал болон суурь үйлчилгээг бий болгож судалгаа болохыг, бий болгож чадаж байгааг судалгаа шинижлээний дүн илэрхийлж байна. Түүгээр ч зогсохгүй, ДНБ-нийхээ багахан хувийг л анхны хөрөнгө оруулалт болгон оруулахад түүнээс хэд дахин илүү ашиг үр дүн авчрахыг баталж байна.

### АМЬДРАЛЫН МӨЧЛӨГИЙН ЭМЗЭГ БАЙДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ НЬ

Хүмүүс бүхий л амьдралынхаа турш тодорхой үе шатанд янз бүрийн түвшний аюул занал, эмзэг байдалтай учирч байна. Эдгээр тодорхой үе шатууд нь хүүхэд нас, өсвөр үе, түүнээс идэр залуу насанд шилжих, дунд наснаас өтөл нас руу шилжих үеүд хамарна. Чадавхийг цаг тухайд нь хөгжүүлэх ажлыг орхигдуулбал хожим засаж залруулах илүү өртөгтэй байх учир цагийг нь олж хөндлөнгөөс оролцож тусламж дэмжлэгээ үзүүлэх нь нэн чухал. Хүний насан туршийн чадавхийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг бүх нийт хүртэхээр хэрхэн дэмжиж болохын бодит жишээ бол хүүхдийн бага насны үеийн хөгжил юм. Гэхдээ, бага насны хүүхдүүдэд зориулсан хөрөнгө оруулалт хийх эх үүсвэр хомс бөгөөд нас ахих тусам нэг хүнд ногдох нийгмийн хөрөнгө оруулалт нэмэгддэг нь нийтлэг үзэгдэл байна. Эрүүл мэнд, боловсрол болон бусад халамжийн зардал нас ахих тусам нэмэгдэх хэдий ч хүний насны эрт үед нь буюу хүүхэд ахуй цагт нь чадавхийг хөгжүүлэхэд дэмжлэг болж чадахгүй байна (Зураг 8).



## НИЙГМИЙН ХАМГААЛЛЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

Ажилгүйдлийн даатгал, тэтгэврийн хөтөлбөрүүд, хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалт зэрэг нийгмийн хамгаалал нь хүнийг амьдралын туршид нь, нэн ялангуяа эмзэг үе шатанд аливаа эрсдэл, саад бэрхшээлээс хамгаалах хэрэгсэл болно. Урьдчилан сэргийлэх нэмэлт дэмжлэг болдог нийгмийн хамгаалал нь хүн ам, гэр бүлийг хөрөнгөө зарах, хүүхдээ сургуулиас гаргах, яаралтай эмчилгээгээ хойшлуулах зэрэг сайн сайхан амьдралд нь урт хугацаанд хохирол учруулах аливаа алхмаас зайлсхийх боломж олгоно.

Цаашилбал, нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх механизм, түгээх сүлжээг ган, зуд зэрэг байгалийн гамшиг, элдэв хямралын үед богино хугацаанд яаралтай түслэмж үзүүлэх хэрэгсэл болгон ашиглаж болно.

Нийгмийн хамгааллын хөтөлбөрүүд бие даасан үйл ажиллагааны эхлэл, дэмжлэг болох эерэг нөлөөтэй. Ажилгүйдлийн даатгал гэхэд л тухайн ажил эрхлээгүй хүнд аль тааралдсанаа барьж авах биш, харин хөдөлмөрийн зах зээл дээрээс өөрийн ажлын туршлага, үр чадвартаа тохирсон нэгийг сонгох боломж олгох замаар хөдөлмөрийн зах зээлийг боловсронгуй болгодог. Өрхийн орлогод дэмжлэг үзүүлэх хөтөлбөр нь хүмүүст гэр бүлээрээ шилжин суурьших хүртэл сайн ажил хайх боломжийг нэмэгдүүлдэгээр хөдөлмөрийн зах зээлийн оролцоог сайжруулж өгнө. Зарим талаар ийм дэмжлэгийг хүмүүсийн ажил хийх сэдлийг бууруулдаг гэж шүүмжлэх нь бий. Мэдээж, энэ бүхэн бодлогоо хэрхэн тодорхойлохоос шалтгаална. Юутай ч, хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалтууд илүү ашигтай бөгөөд тэгш бус байдлыг бууруулахад тодорхой нөлөө үзүүлдэг хангалттай нотолгоо бий. Нийгмийн хамгаалал нь хүний амьдралын буюу хөгжлийн эхэн үед илүү тохиромжтой бөгөөд зардлаа тооцоолох, хянах, ядуурлыг бууруулах зэрэг давуу талуудыг ч бий болгоно. Мөн орлогын хэлбэлзлийг бууруулах замаар зардлын хувирамтгай байдлыг тогтворжуулахад нөлөө үзүүлнэ. Бүх нийтийг хамарсан нийгмийн хамгааллын хүчтэй бодлого нь хувь хүний эрсдэлийг

даван туулах чадварыг дээшлүүлээд зогсохгүй, эдийн засгийг бүхэлд нь чадваржуулах тулгуур болно.

## БҮХ НИЙТИЙН АЖИЛ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ НЬ

Бүх нийтийн бүрэн ажил эрхлэлт нь 1950-60-аад оны макро-эдийн засгийн бодлогын гол цөм болж байсан бөгөөд 1973, 1979 оны газрын тосны хямралын дараах тогтворжилтын үед дэлхий нийтийн анхаарлын хүрээнээс алга болсон юм. Одоо энэхүү зорилгыг сэргээж хөгжил дэвшлийг бэхжүүлэн тогтворжуулах цаг нь болжээ. Бүх нийтийн бүрэн ажил эрхлэлт нь хөдөлмөрийн зах зээлийг өргөжүүлээд зогсохгүй, нийгмийн үйлчилгээний хангамжийг ч сайжруулахад тусална.

Мэдээж, Nordic буюу Умардын загварыг тогтворжуулахад бүрэн ажил эрхлэлт чухал байсан. Учир нь өсөн нэмэгдсэн ажил эрхлэлтийн түвшин нь татварын орлогыг нэмэгдүүлснээр бүх нийтийг хамарсан үйлчилгээний хангамжийг санхүүжүүлэх боломжтой болсон юм.

Бүрэн ажил эрхлэлт нь нийгмийн үр ашгийн хувьд ч хэрэгтэй зүйл юм. Ажилгүйдлийн түвшин өндөр байх нь улмаар нийгэм, эдийн засгийн зардлыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ бүтээгдэхүүний гарцад сөргөөр нөлөөлж, хөдөлмөрийн чадвар болон бүтээмжийг бууруулна. Үйлдвэрлэлийн алдагдал болон түүнтэй холбоотой татварын орлогын бууралт нь ажилгүйдлийн даатгалыг төлөх зэрэг төсвийн зардлыг нэмэгдүүлнэ. Удаан хугацаагаар ажилгүй байх нь эрүүл мэнд (бие махбодь болон сэтгэл санааны) болон амьдралын чанарт (хүүхдийн боловсрол) ноцтой аюул учруулах магадлалтай. Түүнчлэн ажилгүйдэл нь гэмт хэргийн өсөлт, амиа хорлох, хүчирхийлэл, мансууруулах бодис хэрэглэх зэрэг нийгмийн бусад сөрөг үзэгдлийн шалтгаан болно. Иймээс ажлын байрны нийгмийн үр ашиг нь хувийн ашиг болох тогтмол орлогооос хэд дахин илүү ач холбогдолтой.

Ажлын байрны хангамж нь нийгмийн тогтвортой байдал, нийгмийн эв нэгдлийг хангаад зогсохгүй, зохистой ажлын байр хүмүүсийн аливаа гамшиг осол, тодорхойгүй байдлыг даван

Бүх нийтийн ажил эрхлэлт нь улс нийгмийн хөгжлийн бүх л шатанд бодлогын зорилго нь байх ёстой.

туулах чадавхийг бэхжүүлнэ. Хүмүүний амьдралын гол утга, амьжиргааны арга хэрэгсэл болох ажил хөдөлмөр нь хүнийг чадавхижуулах хамт гэр бүл, нийгмийн гишүүдийн хувьд үнэ цэнэтэй зүйл юм. Найдвартай ажлын байр сэтгэл зүйн хувьд ч өндөр ач холбогдолтой.

Бүтцийн өөрчлөлтийг дэмжих бодлого, нэмэгдэж буй албан ёсны ажил эрхлэлт, хөдөлмөр зохицуулах нөхцлүүд зэрэг нь ажил эрхлэлтийн эмзэг байдлыг бууруулахад урт болон дунд хугацаанд хэрэгтэй боловч ажиллах хүчний дийлэнхийн эмзэг байдлыг богино хугацаанд шийдвэрлэхэд хангалтгүй. Тэгэхээр төр засгийн зөв бодлого уламжлалт албан бус хөдөлмөрт оролцсон хэвээр байгаа ажиллах хүчний ихэнх хэсгийн эмзэг байдлыг богино хугацаанд шийдвэрлэж, амьжиргааг нь баталгаажуулахад чухал үүрэгтэй.

Энэ шилжилтийг дэмжиж, бүтээмжтэй ажил эрхлэлтийг өргөнөөр бий болгох нь эдийн засгийн хөгжлийн илүү үр ашигтай стратегийг, ялангуяа нийтэд чиглэсэн хөрөнгө оруулалт, түүний дотор дэд бүтэц, хүний чадавхийг хөгжүүлэх, худалдааны, тэр тусмаа экспортын хувьд идэвхтэй шинэчлэлийг дэмжих стратегийн бодлого хэрэгжүүлэх шаардлагатай.

## ХАРИУЦЛАГАТАЙ ИНСТИТУЦИЙН ТОГТОЛЦОО, НЭГДМЭЛ НИЙГЭМ

Хүний эрсдэлийг давантуулах чадавхийг бий болгоход хариуцлагатай институцийн тогтолцоотой байх шаардлагатай. Ядуус болон эмзэг бүлгийнхнийг хангалттай ажлын байр, эрүүл мэндийн үйлчилгээ, боловсрол эзэмших боломжоор хангахын тулд зохистой бодлого, санхүүгийн эх үүсвэр хэрэгтэй. Тухайлбал, нийгмийн бүлгүүдийн дунд хавтгайрсан тэгш бус байдлыг (хөндлөн тэгш бус байдал) хүлээн зөвшөөрч, бууруулах арга хэмжээ авдаг орнуудын хувьд бүх нийтийг хамруулах зарчмыг тунхаглан, нэгдмэл нийгмийг бий болгож, хямралаас сэргийлэх, сэргэх чадвараар илүү байна.

Амь бөхтэй оршсоор байгаа эмзэг байдал нь түүхийн явцад бий болсон ялгаварлан гадуурхалтаас үүдэлтэй бөгөөд хуучин дэглэмтэй нийгэмд амьдарч

байгаа эмэгтэйчүүд, Өмнөд Африк болон АНУ-ын хар арьстай иргэд, Энэтхэг дэх Далицууд тэндхийн урт хугацаанд тогтсон ёс заншил, нийгмийн хэм хэмжээнээс үүдэн ялгаварлан гадуурхагдсаар, нийгмээс орхигдсоор байна. Мэдрэмжтэй, хариуцлагатай засаглалын байгууллага нь нийгмийн бүхмэдлэн эх үүсвэр болсон шударга бус байдал, эмзэг байдалд шүүмжлэлтэй ханддаг. Улс орнууд эмзэг бүлгийн иргэдийн эрх, ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрөхөд иргэдийн идэвхтэй оролцоо, хүчээ нэгтгэх болон хамтын ажиллагаа зайлшгүй чухал юм.

Төр засаг хөндлөн буюу хавтгайрсан тэгш бус байдлыг арилгахад янз бүрийн бодлогын тусламжтайгаар хөндлөнгөө соролцох боломжтой. Бодлогын шууд оролцоо нь түүхэн шударга бус байдлыг нэн даруй шийдвэрлэх арга байж болох ч түүний урт удаан хугацааны үр дагавар нь тодорхой бус байна. Түүнчлэн энэ нь байнга орших тэгш бус байдлын цаана байгаа тогтолцооны хөтлөгчүүдийг засварлаж чадахгүй байгаа юм.

Богино хэмжээнд шуурхай арга хэмжээ авахын зэрэгцээ хөдөлмөр эрхлэлт, нийгмийн үйлчилгээ, нийгмийн хамгааллыг эмзэг бүлгийнхэнд урт хугацаанд тогтвортой хүртээмжтэй байлгах бодлого хэрэгтэй байна. Эдгээрт зарим албан ёсны урамшууллаас гадна урьдчилан сэргийлэх хууль эрхийн акт гаргах зэрэг хориг арга хэмжээнүүд байж болно. Жишээ нь, төрийн байгууллагууд ажлаа муу хийж байвал хүний эрхэд түлгүүрласан хууль эрхийн актууд эмзэг бүлгийнхэнд эрх зүйн болон олон нийтийн хяналтын хүчийг өгч чадна.

Хүлээцтэй байдлыг бий болгож нэгдмэл нийгмийг хэвшүүлэхэд нийгмийн хэм хэмжээг өөрчлөх явдал зайлшгүй шаардлагатай бөгөөд үүнийг эрсдэлийг даван туулах чадвартай, тэсвэрлэг нийгмийг байгуулах явцад анзааралгүй өнгөрдөг тал бий. Нэгдмэл нийгэм нь хүн амаа аюул гамшгаас илүү найдвартай хамгаалах чадвартай бөгөөд бүх нийтийг хамруулах зарчим дээр суурилсан бодлогуудыг түлхүү хэрэгжүүлдэг.

Нийгмийн нэгдмэл харилцаа хомс байх нь элдэв зөрчил мөргөлдөөн,

---

Хямралд тэсвэртэй бэлэн байх, хохирлыг сэргээх үйл ажиллагаа нь болзошгүй хямралын үр нөлөөг бууруулахад зогсохгүй улс орныг тэсвэрлэг, эрсдэлийг даван туулах чадвартай болгоно.

хүчирхийлэл, ялангуяа байгалийн нөөц баялгийн ашгаас хүртэх орлогын тэгш бус хуваарилалт, түргэн хувирч буй нийгэм эдийн засгийн өөрчлөлтүүд, байгаль цаг уурын өөрчлөлтөөс үүдсэн гамшиг болон эдийн засгийн хямралыг зохицуулж чадахгүй зэрэг сөрөг үзэгдлийн эх үүсвэр болно. Чухамдаа, эрх тэгш байдал, тэгш оролцоо, шударга байдлыг хангах өргөн зорилго тавьснаар төрийн байгууллагуудыг бэхжүүлж, энэ нь эргээд нийгмийн харилцааг гүнзгийрүүлнэ.

### ХЯМРАЛЫГ БЭЛТГЭЛТЭЙ ДАВАХ, НӨХӨН СЭРГЭХ ЧАДАВХИЙГ БИЙ БОЛГОХ НЬ

Байгалийн гамшиг нь ядуурал, тэгш бус байдал, байгаль орчны сүйрэл, засаглалын сүлрэл зэрэг эмзэг байдлыг улам гүнзгийрүүлнэ. Бэлтгэлгүй, эрсдэлийн талаар мэдээлэл муутай, урьдчилан сэргийлэх чадвар сул улс орон болон хүмүүс гамшгийн нөлөөнд илүү хүндээр өртөнө. Үндэсний болон бүс нутгийн хэмжээнд эрсдэлийг эрт зарлан мэдээлэх, сэргийлэх системийг сайжруулахад ихээхэн анхаарах хэрэгтэй. Байгалийн гамшиг ихэвчлэн нэгэн зэрэг хэд хэдэн орны газар нутгийг дамждаг тул эрт зарлан мэдээлэх системийг боловсронгуй болгоход бүсийн хамтын ажиллагаа илүү үр дүнтэй байх болно. Эрт зарлан мэдээлэх нь гамшгийн эрсдэлийг бууруулах чухал хэсэг бөгөөд гамшгаас хүний амь насыг хамгаалах, материалын болоод эдийн засгийн бусад хохирлыг эрс багасгах ач холбогдолтой. Улс орны бэлтгэл сайн байх эсэх, бодлогын тогтолцоо нь боловсронгуй байгаа эсэхээс үл хамааран гамшиг тохиолдоход их бага хэмжээгээр зайлшгүй сүйрэлт үр дагавар дагуулна. Ийм үед гол зорилго нь нийгмийн, материалын болон байгууллагын эрсдэлийг даван туулах чадварыг нэмэгдүүлэхийн хамт сэргээн босгох ажилд чиглэгдэх хэрэгтэй. Төрийн байгууллага нь сул дорой, зөрчил ихтэй бол цаг уурын цочмог сорилтыг сөрөх асуудал хүндрэлтэй болно.

Улс орны эрсдэлийг даван туулах чадавхид гамшгийн дараа сэргээн босгох ажлыг хир сайн түргэн шуурхай зохион байгуулах чадавхи бас орно. Үүнд гамшгийн хохиролт үр нөлөөг арилгах,

нийгэм эдийн засгийн сөрөг үр дагавраас зайлсхийх тусгай арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх шаардлагатай. Гамшиг цочролыг даван туулах бэлтгэл муутай, бэлэн биш улс нийгэм илүү хохирол сүйрэл амсах ба сэргээн босгох ажил удаашралтай, хүндрэлтэй байх нь мэдээж.

Нийгмийн харилцааны эв нэгдлийг бий болгоход улс орнуудын хүчин чармайлт үндэсний онцлог, бусад шалтгаанууд нь өөр өөр байх боловч зарим нэг нийтлэг элементүүдийг тодорхойлж болно. Ялгаварлан гадуурхах, ангилан тусгаарлахтай тэмцэж буй төрийн бодлого, төрийн байгууллагууд нь өөриймсөг мэдрэмж төрүүлэх, итгэлцлийг бий болгох, урагш тэмүүлэх боломж олгож байгаагаараа зөрчлийг бууруулж байна. Олон нийтийн ойлголт мэдлэг, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх нь энх тайвны төлөө дэмжлэгийг өргөжүүлэх, сөргөлдөөнийг багасгах боломж олгоно. Хариуцлагатай, найдвартай хамтрагчдыг татан оролцуулах замаар хэт түйлширсэн, сөргөлдөгч талуудын дунд эв нэгдэл итгэлцлийг бий болгож, найдвар төрүүлснээр сонгууль хэрхэн явуулахаас эхлээд үндсэн хуулийн зүйл заалт хүртэл үндэсний хэмжээний асуудлуудаар зөвшилцөлд хүрэх боломжтой болно. Ажлын байр, амьжиргаанд хөрөнгө оруулалт хийх нь ард иргэд болоод хувь хүмүүст гамшиг хямралаас богино хугацаанд гарч, цаашид тулгарч болзошгүй саад бэрхшээлийг даван туулах чадавхитай болоход нь тусална.

### АХИЦ ДЭВШИЛ, ХАМТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ГҮНЗГИЙРҮҮЛЭХ НЬ

Даяаршил улс орнуудыг ойртуулж, шинэ шинэ боломжуудаар хангаж өгч байна. Гэхдээ энэ нь гамшигт үйл явдлууд асар хурдан тархах, дамжих эрсдэлийг ч бас нэмэгдүүлж байна.

Сүүлийн үед болж өнгөрсөн үйл явдлууд нь даяаршил хүнсний аюулгүй байдлаас эрчим хүчний хангамж хүртэл, санхүүгийн зохицуулалтаас цаг уурын өөрчлөлт хүртэл дэлхий нийтийн хамарсан асуудлуудыг хэрхэн шийдвэрлэж байгаад томоохон цоорхой байгааг харуулж байна.

Эмзэг байдал нь гарал үүсэл, үр нөлөөгөөрөө улам бүр дэлхий нийтийн шинжтэй болж, олон улсын хамтын ажиллагаа, илүү сайн засаглалыг шаардаж байна.



Дэлхийн засаглалын дөрвөн чухал асуудал

Хёго-гийн Үйл ажиллагааны Хүрээ

2005 онд 168 улс баталж зөвшөөрсөн Хёго-гийн үйл ажиллагааны хүрээ нь 2015<sup>1</sup> он гэхэд дэлхийн институтийн чадавхийг бий болгох, гамшиг эрсдэлийг эрт зарлан мэдээлэх тогтолцоог дэмжих, аюулгүй байдал, эрдэлийг даван туулах арга замыг дэмжих, эмзэг байдлын шалтгааныг бууруулах, гамшигт бэлэн байх, хариу арга хэмжээ авахад чиглэсэн зорилго, үйл ажиллагааны цогц юм.

Тус Хүрээ нь гамшгийн эрсдэлийг үндэсний, бүс нутгийн, болон олон улсын хэмжээнд бууруулахад улс орнуудын хамтын ажиллагааг чиглүүлсэн. Гэхдээ хийх ажил их, ахиц дэвшил улс орнуудын хэмжээнд, үйл ажиллагааны салбарт ижил байж чадахгүй байна. Түлгэмдэж байгаа асуудлууд нь шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулж ашиглах, олон хэлбэрийн аюул гамшгийн орчинд эрт зарлан мэдээлэх тогтолцоог бий болгох, улс орнуудын гамшгийн эрсдэлийг бууруулах ажлыг тогтвортой хөгжлийн бодлоготойгоо уялдуулах, үндэсний болон олон улсын түвшинд төлөвлөх чадварыг сайжруулах зэрэг болно.

Дэлхийн Хүмүүнлэгийн дээд хэмжээний уулзалт

2016 онд төлөвлөгдсөн Дэлхийн Хүмүүнлэгийн дээд хэмжээний Уулзалт нь хүмүүнлэгийн үйл ажиллагааг илүү дэлхий нийтийн, үр дүнтэй, хүртээмжтэй болгох, асар хүрдтай өөрчлөгдөж буй дэлхийн хэрэгцээнд илүү нийцүүлэх зорилготой.<sup>2</sup> Энэ нь олон улсын хүмүүнлэгийн байгууллагуудын үйл ажиллагааг эмзэг байдлыг бууруулах болон эрсдэлийн удирдлагын асуудлын эргэн тойронд зохицуулах боломж олгоно.

Өсөн нэмэгдэж буй хүмүүнлэгийн нарийн төвөгтэй онцгой байдалд хариулах нь хүмүүнлэгийн эрсдэлийг удирдах, бууруулах аргаа тодорхойлж хэрэгжүүлэхээс эхэлнэ. Дээд хэмжээний уулзалт нь хөтөлбөрийг төлөвлөх, тэргүүлэх ач холбогдол өгөх, санхүүжүүлэхэд хүмүүнлэгийн болон хөгжлийн төлөөх байгууллагууд хэрхэн системтэй, уялдаатай хандаж байгааг, мөн эдийн засаг, нийгэм, байгаль орчны хүрээнд үйл ажиллагааг хэрхэн зохицуулж болохыг үнэлэх юм. Түүнчлэн хүмүүнлэгийн болон хөгжлийн стратегийг хамтран боловсруулахад нөлөөлөлд өртсөн улс орон, хандивлагч болон олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих юм.

Уур амьсгалын өөрчлөлт - 2 хэмийн хязгаар

2009 оны Копенгагены Зөвшилцөл, 2010 оны Канкуны Гэрээгээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Уур амьсгалын өөрчлөлтийн чуулганд оролцогч талууд (195) дэлхийн цаг агаарын дундаж өсөлтийг аж үйлдвэржилтийн өмнөх үеийнхээс цельсийн 2 градусаас багад хязгаарлахаар тохиролцжээ.<sup>3</sup> Энэхүү амлалт нь гамшгийн эвдэн сүйтгэх үр нөлөөг хязгаарлах дээд хэмжээ 2 градусаас ихгүй байна гэсэн шинжлэх ухааны зөвшилцөл дээр тулгуурласан аж. Энэ зорилтыг хангахад олон улсын хамтын нийгэмлэгийнхний авсан үүрэг амлалт хангалттай биш нь ойлгомжтой. Уур амьсгалын асуудлаархи Засгийн газар хоорондын зөвлөлийн урьдчилан тооцсон таамаглалаар дэлхийн цаг агаар 21-р зууны эцэс гэхэд 1.5 хэмээр дулаарна гэж дүгнэжээ.<sup>4</sup> Хэрвээ хорт хийн ялгаруулалтыг бууруулах талаар дорвитой алхам хийхгүй бол энэ хэм 2-д амархан хүрнэ. Тавьсан зорилгодоо хүрэх нь эдийн засаг болон техникийн талаасаа боломжтой ч хорт хийн өнөөгийн түвшин болон 2020 он гэхэд 2-оос доош байх түвшиний ялгааг арилгах улс төрийн зоримог шийдэл хэрэгтэй байна.

2015 оноос хойшхи асуудал ба тогтвортой хөгжлийн зорилтууд

2015 оноос хойшхи хөгжлийн асуудал болон тогтвортой хөгжлийн зорилтуудыг боловсруулах явцад олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө эмзэг байдлыг бууруулах асуудлыг олон улсын хөгжлийн хүрээний нэн тэргүүний зорилт болгон дэвшүүлэх боломж гарч байна.

Мянганы хөгжлийн зорилтууд ядуурлыг бууруулж, олон хүний амьдрал сайжрахад тусалсан. Гэхдээ гамшгийн эрсдэлийг бууруулж, хүмүүсийн дасан зохицох, даван туулах чадварыг сайжруулахгүй бол ахиц дэвшил тасралтгүй үргэлжлэх баталгаа байхгүй байна. Эдгээр зорилтыг ядуурлыг тэглэхэд хүрэх зорилтыг ядууралгүй байх болгон өргөжүүлж, бусад чиглэлд ч ахиц дэвшил олох ёстой. Байгалийн гамшиг, цаг уурын өөрчлөлт, санхүүгийн доройтолд хамгийн эмзэг, өртөмтгий хүмүүсийг тусгайлан чадавхижуулж хамгаалах ёстой. Эмзэг байдлыг бууруулах зорилтыг ирээдүйн хөгжлийн асуудлын төвд тавих нь ахиц дэвшлийг байнгын, тогтвортой байлгах цор ганц зам байх болно.

Тайлбар

1. UNISDR 2005. 2. UNOCHA 2014. 3. НҮБҮӨСК-ийн 2009, 2011 он. 4. IPCC 2013.

Урьдчилан сэргийлэх болон хор үршгийг бууруулах арга хэмжээ авах чадваргүй дэлхий нийтийн өнөөгийн засаглалтай хэвээр байвал эдгээр хил дамнасан асуудлууд ирэх хэдэн арван жилд ч үргэлжлэх төлөвтэй байна. Бодлого боловсруулагчид болон улс орнуудын удирдагчид өөрсдөө эдгээр өөрчлөлтийн хурд, цар хүрээний тэлэлтэд бэлэн биш байна.

## ДЭЛХИЙ НИЙТИЙН НИЙГМИЙН ЗӨВШИЛЦӨЛИЙН ЭЛЕМЕНТҮҮД

Нэг улс орон, үндэстний хэмжээндээ чадавхийг сайжруулж, сонголтыг хамгаалж болох боловч энэхүү үндэстний хэмжүүр нь дэлхий нийтээрээ анхааран дэмжсэн тохиолдолд илүү хялбар хүчин төгөлдөр болно. 2015 оноос хойшхи хөгжлийн асуудлууд болон тогтвортой хөгжлийн зорилтуудыг боловсронгуй болгох нь олон улсын хамтын нийгэмлэг, гишүүн орнуудын хувьд нийгмийн үйлчилгээ, нийгмийн хамгааллын суурь, бүрэн хэжээнд ажил эрхлэлтийг дэлхийн хамтын нийгэмлэгийн гол зорилт болгон дэвшүүлэх боломж олгож байна. Дэлхий нийтээрээ энэ зорилгод нэгдсэнээр тухайн улс орны хувьд хүн бүрээ ажилтай байлгаж, нийгмийн үйлчилгээг хангах өөрийн онцлогтоо илүү тохиромжтой үндэстний бодлогоо тодорхойлох орон зай гарч болох ч бүх улс орнуудын хамтын хүчээр үйл ажиллагаагаа нэгтгэн санхүүгийн болон бусад дэмжлэг авах боломжтой болох учир олон улсын хэлэлцээр, зөвшилцөл маш чухал.

## ДЭЛХИЙ НИЙТИЙН ЗАСАГЛАЛЫГ САЙЖРУУЛАХ НЬ

Өнөөдөр, цаг уурын өөрчлөлтөөс эхлэн эдийн засгийн хямрал, зөрчил мөргөлдөөн, нийгмийн тогтворгүй байдал гээд шийдэх олон асуудлууд зэрэг зэрэг тулгарч байна. Зарим аюул заналыг бууруулахын тулд тодорхой бодлого шаардлагатай байгаа ч санхүүгийн тогтворгүй байдал, худалдааны тэнцвэрт бус нөхцөл, уур амьсгалын өөрчлөлтөөс өмнө шийдэх нэн тэргүүний, томоохон асуудал нь засаглалын тогтолцоог өөрчлөх явдал юм. (Шигтгээ 2).

Зарим хямрал гамшгийг бууруулахын тулд бодлогын өөрчлөлтүүд ч бас шаардлагатай.

Дэлхий нийтээрээ шийдвэрлэх асуудлуудын жагсаалт урт, бидний өгөх зөвлөмж багагүй ч, нийтийн хэрэгцээнд нийцсэн бараа бүтээгдэхүүнээр хангахад байгууллагуудын анхаарлыг хандуулснаар санхүүгийн болон худалдааны системийг зохицуулж, байгаль орчинд учрах аюул

заналыг бууруулж, болох нь ойлгомжтой. Зөвлөмжид санхүүгийн механизм, санхүүгийн тогтворгүй байдлыг зогсоох, хор үршгийг багасгах асуудал, мөн байгууллагуудын хөрвөх чадварыг бий болгох, хангах зэрэг асуудал орно. Худалдааны хоёр талт хэлэлцээрт тулгуурласан хөдөө аж ахуй, үйлчилгээний салбарт хийгдэх худалдааны журмыг эргэж харах, худалдааны бус заалтуудыг оруулснаар бусад салбарт үндэстний бодлогын орон зайг нөхөх асуудал ч хамрагдана. Цаг уурын өөрчлөлт нь дэлхий нийтийн хөгжлийн тулгамдсан чухал асуудал мөн. Дэлхий нийтийн хэрэгцээнд нийцсэн нэгэн бүтээгдэхүүн болох цаг уурын тогтвортой байдал алдагдсанаас байгаль цаг уурын эрс үзэгдэлд эрсдэх болон хүнсний хямралын эрсдэл дэлхийн янз бүрийн бүс нутагт давтагдах аюул бий болж байна. Энд ч яаралтай арга хэмжээ авах шаардлагатай байна. Нэг улс орны хүрээнд үйл ажиллагааны сайн эхлэл байгаа ч олон улсын хамтын ажиллагаа нь асуудлыг бүрэн дүүрэн шийдэх гол түлхүүр юм.

## АЮУЛГҮЙ ДЭЛХИЙН ТӨЛӨӨХ ХАМТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Аливаа хямрал, цочролыг багасгахын тулд засаглалын тогтолцоог залруулах замаар, эсвэл хүмүүсийн дасан зохицох чадварыг сайжруулах замаар олон үндэстнийг хамарсан аюулын эрсдэлийг бууруулах нь улс орнууд, олон улсын байгууллагуудын зүгээс илүү нягт хамтын ажиллагаа, манлайллыг шаардаж байгаа юм. Түүнчлэн тэргүүлэх чиглэлээ зөв тодорхойлоход илүү уялдаа холбоотой хандах хэрэгтэй бөгөөд иргэний нийгэм болон хувийн хэвшлийн зүгээс системтэй байнгын оролцоо маш чухал.

Зохицуулалт, хамтын ажиллагаа, манлайлал дутагдвал дэлхий нийтийн хэмжээний олон асуудлыг шийдвэрлэж, эмзэг байдлыг бууруулахад олж буй ахиц дэвшил саарна. Хэдийгээр олон улсын засаглалын хамтын ажиллагаан дахь зогсонги байдлыг залруулж, эрчимжүүлэх алхам хийгдээгүй байгаа ч дэлхий ертөнц сүүлийн арван жилд маш эрчтэй өөрчлөгдөж байна. Дэлхий нийтээрээ

яаралтай шийдвэрлэх асуудлууд урьд урьдаас илүү тулгамдаж, геополитикийн орчин ч өөр болж байна. 2013 оны Дэлхийн Хүний хөгжлийн илтгэлд онцолсон Өмнөдийн сэргэлт дэлхий нийтийн засаглалыг илүү өргөн төлөөлөлтэй, илүү үр дүнтэй болох боломжийг олгосон. Гэхдээ энэ нь олон улсын хамтын ажиллагаа, манлайлалд шинэ шийдлийг шаардаж байна.

Худалдаа, цаг уур, байгаль орчин, санхүү, шилжилт хөдөлгөөн гэх мэт асуудлуудаар тус тусдаа байгууллагууд дагнан анхаарч дэлхий нийтийн засаглал салангид “торх”-нд зохион байгуулагдах хандлагатай байна. Ингэвэл нийтийн өмнө тулгамдсан сорилтуудын хэтийн төлөв, улс орнуудын болон олон улсын байгууллагуудын үйл ажиллагааны давхардал, зөрчилдөөнийг тодорхойлоход хүндрэлтэй болно.

Дэлхий нийтийн засаглалын олон талт, заримдаа давхарддаг зохион байгуулалтын асуудлуудад иж бүрэн

нарийн үнэлгээ хийж, дэлхий нийтийн хамтын ажиллагааг үр дүнтэй болгох, хамгийн анхаарал татсан салбаруудад чиглүүлэх хэрэгтэй. Энэхүү үнэлгээг дэлхий нийтийн тулгамдсан асуудлуудад системийн бодит төлөвөөс нь хандаж, эрх бүхий этгээдүүдэд зөвлөмж, зөвлөгөө өгөх чадвартай, бие даасан шинжээчдээс бүрдсэн улс төрийн бус байгууллага гардан гүйцэтгэвэл тохиромжтой юм.

Иргэдийн шууд оролцоотой байж засаглал сайжирдаг. Олон нийттэй ойр дотно харилцаатай байж Засгийн газар ард түмний эмзэг байдлын тухай зөв мэдээлэл авч, бодлогын үйл ажиллагааны үр нөлөөг хянах боломжтой болно. Ийм харилцаа нь төрийн шууд оролцоо, олон нийтийн эх үүсвэрийг үр дүнтэй болгоно. Хүмүүс эрх чөлөөтэй, аюулгүй, чадвартай, шийдвэр гаргахад нөлөөлөх дүү хоолойтой байвал оролцоо үр дүнтэй байна. Мөн тэд нягт хамтран ажилласнаар хүссэн үр дүндээ хүрч чадах өөрсдийн хүчиндээ итгэдэг байх ёстой.

\* \* \*

Өмнө олонтаа дэвшүүлж байсан илүү хүртээмжтэй, илүү тогтвортой, илүү чадавхитай дэлхий нийтийн өсөлт, хөгжлийг хангах зорилго нь дэлхий нийтийн дундын өмчийн хэтийн төлөвийг эерэгээр харах, “бидний хүсэж байгаа дэлхий” нь байгалийн болон хүний гараар бүтсэн нийтийн бараа бүтээгдхүүнээр хэрхэн хангахаас ихээхэн хамааралтайг хүлээн зөвшөөрөхийг шаардаж байна. Зах зээл чухал ач холбогдолтой боловч нийгмийн болон байгаль орчны зохистой хамгааллаар хангаж чадахгүй. Улс орнууд, дангаараа юм уу, хамтдаа, илүү хүчтэй, илүү ойрхон хамтрах хүсэл эрмэлзэлтэйгээр нэгдэж, үндэсний бодлогоо уялдуулан, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх шаардлагатай. Засгийн газрууд хүн амаа ажилтай байлгаж, хамгааллаар хангахын тулд бодлогын орон зайгаа өргөжүүлэх ёстой. Иргэний нийгэм улс төрийн хүсэл сонирхлыг бүрдүүлж чадах боловч зөвхөниргэд хил дамнасан

хамтын ажиллагаа, олон нийтийн бараа бүтээгдэхүүний үнэ цэнийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд ингэж чадна.

Ахиц дэвшил ажил болдог. Мянганы Хөгжлийн зорилтуудын ихэнхийг улс үндэсний хэмжээнд 2015 он гэхэд биелүүлсэн байх төлөвтэй байгаа боловч амжилт өөрөө ирэхгүй, байнга байгаад байхгүй. Хөгжлийг нэг алхам урагшлуулахын тулд эмзэг байдал, эрсдэл, гамшгийн эсрэг олсон ололт амжилтаа хамгаалан бататгаж, даван туулах чадвараа нэмэгдүүлэн, ахиц дэвшлийг гүнзгийрүүлэх шаардлагатай. Хүн амын эмзэг бүлгийг тодорхойлж анхааралдаа авах, тэгш бус байдлыг бууруулах, бүтцийн эмзэг асуудлыг шийдвэрлэх нь хөгжлийг хүний амьдралынх нь түршид, үеэс үед дамжуулан тогтвортой баталгаажуулахад өндөр ач холбогдолтой.

---

Даяаршил  
илүү хөгжиж  
хүний хөгжлийг  
хамгаалахын тулд  
дэлхий нийтийн  
хүчин чармайлт  
шаардлагатай  
дэлхий нийтээрээ  
зорилгоо болгон  
дэмжлэг үзүүлбэл  
үндэсний  
хэмжүүрүүд ч  
ашиглахад илүү  
хялбар болно.

## Эмзэг байдлын тухай эргэцүүлээ өргөжүүлэх нь

НҮБ нэлээд эртнээс хүний аюулгүй байдлыг бүх талаар нь онцгойлон анхаарч ирсэн. Намайг Дэлхийн Банкны ерөнхий эдийн засагч байх үед бид мянга мянган ядуу хүмүүсийн дунд тэдний санааг хамгийн их зовоосон асуудал юу болохыг тогтоохоор судалгаа явуулахад жагсаалтын эхэнд (мэдээж, орлогын хомсдол болон амьдралын чухал асуудлуудаар дуу хоолойгоо хүргэж чадахгүй байгаагийн хамт) эмзэг байдал нь аюул болон орж байсан.

Үндсэндээ эмзэг байдал нь амьжиргааны түвшин тодорхой хэмжээнд буурах үзэгдэл гэж тодорхойлогддог бөгөөд энэ нь удаан хугацаанд үргэлжилж, амьжиргааны түвшин нь зөвшөөрөгдөх босгоноос доогуур орж доройтлын хэмжээнд хүрвэл онцгой анхаарал татаж эхэлнэ.

Эдийн засагчид ДНБ-ийг дагнан анхаарч ирсэн уламжлалт хандлага нь эмзэг байдлын асуудлыг харалгүй анхаарлын гадна орхиод хүргэсэн. Хувь хүмүүс эрсдлээс зайлсхийдэг. Тэдний эмзэг гэдгийг ухамсарлах нь халамжийн бодлогыг ихээр алдсаныг, тэр ч байтугай хүмүүс хямралын үр дагавартай нүүр тулгарахаас өмнө энэ асуудлыг орхигдуулсныг ойлгоход хүргэнэ. Бидний системийн алдаа нь хувь хүн, нийгмийн сайн сайхны аюулгүй байдлын ач холбогдлыг үнэлээгүй явдал бөгөөд энэ нь Эдийн засгийн үйл ажиллагаа, нийгмийн дэвшлийг хэмжих олон улсын комиссоос ДНБ-ийг шүүмжлэх гол шүүмжлэл байсан юм.

Хэрвээ бид эмзэг байдлыг бууруулах бодлого боловсруулах гэж байгаа бол, чухам юу ийм эмзэг

байдлыг бий болгодгийг өргөн хүрээтэй авч үзэх нь чухал. Хувь хүн, нийгэм нь эдийн засагчдын нэрлэдэг “цочрол” буюу амьдралын стандартыг ямар нэгэн хэмжээгээр буурахад хүргэж болзошгүй гэнэтийн гамшигт үзэгдэлд зайлшгүй өртдөг. Цочрол их байхын хэрээр илүү гүнзгий удаан үргэлжлэх бөгөөд эмзэг байдал ч, бусад зүйл ч тэр хэмжээгээр их байна. Гэхдээ хувь хүн, нийгэм цочролыг даван туулах механизмыг боловсруулдаг. Зарим нийгэм, зарим эдийн засаг цочролыг даван туулах чадавхиа сайжруулах тал дээр бусдаасаа илүү сайн байдаг. Хүчтэй цочролд өртсөн ч хүн амын ихэнх хэсгийг орхигдуулсан, эрсдэлийг даван туулах хангалттай механизмгүй нийгэмд эмзэг байдал илүүтэй үүсдэг.

Эмзэг байдалд хамгийн ихээр нөлөөлдөг, бусад хүчин зүйлс хор хохиролтой, сөрөг нөлөө үзүүлдэг нь тэгш бус байдал бөгөөд эмзэг байдлыг янз бүрээр өөгшүүлсээр байна. Тэгш бус байдал нь тогтворгүй байдлыг бий болгож, эдийн засаг дахь том савалгааны давтамжийг ч нэмэгдүүлж байна. Тэгш бус байдлын туйлшрал гэдэг нь нийт хүн амын ихэнх хэсэг ядууралд орж, дасан зохицох, даван туулах чадваргүй болохыг хэлнэ. Эдийн засгийн тэгш бус байдлын туйлшрал улс төрийн тэгш бус байдалд зайлшгүй хүргэх ба үр дүнд нь Засгийн газрууд нь нийгмийн хамгааллын тогтолцоог хангаж том цочролын үр дагаварт өртсөн хүмүүсийг хамгаалах хүсэлгүй болох магадлалтай юм. Бид тэгш бус байдлыг зөвхөн ёс суртахууных нь асуудлын хувьд төдийгүй, эдийн засгийн суурь асуудал талаас нь эргэцүүлэн, хүний хөгжилтэй, ялангуяа эмзэг байдлын дүн шинжилгээтэй үялдуулан бодож эхлэх хэрэгтэй байна.

(Товчилсон хувилбар)

## Улс орнуудын 2013 оны Хүний Хөгжлийн Индексийн эрэмб, 2012 онтой харьцуулсан өөрчлөлт

Австрали	2	0		Испани	27	0		Перу	82	0	
Австри	21	0		Итали	26	0		Польш	35	-1	↓
Азербайжан	76	-1	↓	Кабо-Верде	123	-2	↓	Португал	41	0	
Албани	95	2	↑	Казахстан	70	0		Руанда	151	0	
Алжир	93	0		Камбож	136	1	↑	Румын	54	1	↑
Ангол	149	0		Камерун	152	0		Сальвадор	115	0	
Андорра	37	0		Канад	8	0		Самоа	106	-2	↓
Антигуа ба Барбуда	61	-1	↓	Катар	31	0		Сан-Томе ба Принсипи	142	-1	↓
АНУ	5	0		Кени	147	0		Саудын Араб	34	0	
Арабын Нэгдсэн Эмирт Улс	40	0		Кипр	32	0		Свазиланд	148	0	
Аргентин	49	0		Киргизстан	125	1	↑	Сейшелийн Арлууд	71	-1	↓
Армен	87	0		Кирибати	33	0		Сенегал	163	-3	↓
Афганистан	169	0		Колумб	98	0		Сент Люсиа	97	-4	↓
Багамын Арлууд	51	0		Коморын арлууд	159	-1	↓	Сент-Винсент ба Гренадин	91	0	
Балба	145	0		Конго	140	0		Сент-Китс ба Невис	73	0	
Бангладеш	142	1	↑	Конго (Ардчилсан Улс)	186	1	↑	Серб	77	1	↑
Барбадос	59	-1	↓	Коста Рика	68	-1	↓	Сингапур	9	3	↑
Бахрейн	44	0		Кот д'Ивуар (Зааны Ясан Эрэг)	171	0		Сири	118	-4	↓
Беларус	53	1	↑	Куба	44	0		Словак	37	1	↑
Белиз	84	0		Кувейт	46	-2	↓	Словен	25	0	
Бельги	21	0		Лаос	139	0		Соломоны Арлууд	157	0	
Бенин	165	0		Латви	48	0		Судан	166	0	
Болгар	58	0		Лесото	162	1	↑	Суринам	100	1	↑
Боливи	113	0		Либериа	175	0		Сьерра-Леоне	183	1	↑
Босни-Герцеговин	86	0		Ливан	65	0		Тажикистан	133	1	↑
Ботсван	109	-1	↓	Ливи	55	-5	↓	Тайланд	89	0	
Бразил	79	1	↑	Литва	35	1	↑	Танзани	159	1	↑
Бруней	30	0		Лихтенштейн	18	-2	↓	Того	166	1	↑
Буркина Фасо	181	0		Люксембург	21	0		Тонга	100	0	
Бурунди	180	0		Маврикий	63	0		Төв Африкийн БНУ	185	0	
Бутан	136	0		Мавритан	161	-2	↓	Тринидад ба Тобаго	64	0	
Вануату	131	-3	↓	Мадагаскар	155	0		Тунис	90	0	
Венесуэл (Боливарын БНУ)	67	-1	↓	Македон	84	1	↑	Турк	69	0	
Вьетнам	121	0		Малави	174	0		Туркменистан	103	1	↑
Габон	112	-1	↓	Малайз	62	0		Уганда	164	0	
Гайана	121	0		Мали	176	0		Узбекистан	116	0	
Гайти	168	0		Мальдив	103	0		Украин	83	0	
Гамби	172	0		Мальта	39	0		Унгар	43	0	
Гана	138	0		Мексик	71	-1	↓	Уругвай	50	2	↑
Гватемал	125	0		Микронези	124	0		Фижи	88	0	
Гвиней	179	-1	↓	Мозамбик	178	1	↑	Филиппин	117	1	↑
Гвиней-Бисау	177	0		Молдав	114	2	↑	Финлянд	24	0	
Герман	6	0		Монгол	103	3	↑	Франц	20	0	
Гондурас	129	0		Монтенегро	51	1	↑	Хонг Конг	15	0	
Грек	29	0		Морокко	129	2	↑	Хорват	47	0	
Гренада	79	-1	↓	Мьянмар	150	0		Хятад	91	2	↑
Гүрж	79	2	↑	Намиби	127	0		Чад	184	-1	↓
Дани	10	0		Нигер	187	-1	↓	Чех	28	0	
Доминик	93	-1	↓	Нигери	152	1	↑	Чили	41	1	↑
Доминиканы БНУ	102	0		Нидерланд	4	0		Швед	12	-1	↓
Египет	110	-2	↓	Никарагуа	132	0		Швейцар	3	0	
Жибути	170	0		Норвег	1	0		Шинэ Зеланд	7	0	
Замби	141	2	↑	Нэгдсэн Вант Улс	14	0		Шри Ланка	73	2	↑
Зимбабве	156	4	↑	Оман	56	0		Эквадор	98	0	
Зүүн Тимор	128	1	↑	ОХУ	57	0		Экваторын Гвиней	144	-3	↓
Йемен	154	0		Өмнөд Африк	118	1	↑	Энэтхэг	135	0	
Израиль	19	0		Өмнөд Солонгос	15	1	↑	Эритрей	182	0	
Индонези	108	0		Пакистан	146	0		Эстони	33	0	
Йордан	77	0		Палау	60	0		Этиоп	173	0	
Ирак	120	0		Палестин	107	0		Ямайка	96	-3	↓
Иран	75	-2	↓	Панам	65	2	↑	Япон	17	-1	↓
Ирланд	11	-3	↓	Папуа Шинэ Гвиней	157	-1	↓				
Исланд	13	0		Парагвай	111	0					

Тайлбар: Эерэг, сөрөг тоо болон сум нь тухайн улсын эрэмб 2013 онд 2012 оныхоос хэдэн байраар өгссөн, уруудсаныг илэрхийлж байгаа болно; хоосон байвал өөрчлөлт гараагүйг илтгэнэ.

# ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИНДЕКС

	Хүний Хөгжлийн Индекс			Тэгш бус байдлыг тооцсон ХХИ		Жендэрийн тэгш бус байдлын индекс		Жендэрийн хөгжлийн индекс		Олон хэмжүүрт ядуурлын индекс	
	Утга	Утга	ХХИ-ийн зэрэглэл	Тэгш бус байдлын коэфф	Утга	Рейтинг	Утга	Рейтинг	Утга	Утга	
<b>ХХИ-ийн рейтинг</b>	2013	2013	2013 <sup>a</sup>	2013	2013	2013	2013	2013	2013 <sup>b</sup>	Утга	Утга <sup>c</sup> судалгаа <sup>d</sup> хийсэн он
<b>ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИНДЕКС МАШ ӨНДӨР ҮЗҮҮЛЭЛТТЭЙ ОРНУУД</b>											
1 Норвег	0,944	0,891	0	5.5	0,068	9	0,997	5	..	..	
2 Австрали	0,933	0,860	0	7.5	0,113	19	0,975	40	..	..	
3 Швейцарь	0,917	0,847	-1	7.6	0,030	2	0,953	76	..	..	
4 Нидерланд	0,915	0,854	1	6.6	0,057	7	0,968	51	..	..	
5 АНУ	0,914	0,755	-23	16.2	0,262	47	0,995	7	..	..	
6 Герман	0,911	0,846	1	7.0	0,046	3	0,962	61	..	..	
7 Шинэ Зеланд	0,910	..	..	..	0,185	34	0,971	47	..	..	
8 Канад	0,902	0,833	-2	7.5	0,136	23	0,986	24	..	..	
9 Сингапур	0,901	..	..	..	0,090	15	0,967	52	..	..	
10 Дани	0,900	0,838	0	6.8	0,056	5	0,989	17	..	..	
11 Ирланд	0,899	0,832	-1	7.4	0,115	20	0,965	56	..	..	
12 Швед	0,898	0,840	3	6.4	0,054	4	1,004	6	..	..	
13 Исланд	0,895	0,843	5	5.6	0,088	14	0,982	30	..	..	
14 Нэгдсэн Вант Улс	0,892	0,812	-4	8.6	0,193	35	0,993	13	..	..	
15 Хонг Конг, Хятад	0,891	..	..	..	..	..	0,969	49	..	..	
15 Солонгос (БНУ)	0,891	0,736	-20	16.8	0,101	17	0,940	85	..	..	
17 Япон	0,890	0,779	-6	12.2	0,138	25	0,951	79	..	..	
18 Лихтенштейн	0,889	..	..	..	..	..	..	..	..	..	
19 Израиль	0,888	0,793	-4	10.4	0,101	17	0,984	29	..	..	
20 Франц	0,884	0,804	-2	8.9	0,080	12	0,989	17	..	..	
21 Австри	0,881	0,818	4	7.1	0,056	5	0,935	91	..	..	
21 Бельги	0,881	0,806	0	8.5	0,068	9	0,977	38	..	..	
21 Люксембург	0,881	0,814	3	7.5	0,154	29	0,961	66	..	..	
24 Финлянд	0,879	0,830	9	5.5	0,075	11	1,006	8	..	..	
25 Словен	0,874	0,824	9	5.7	0,021	1	1,006	8	..	..	
26 Итали	0,872	0,768	-11	1.6	0,067	8	0,962	61	..	..	
27 Испани	0,869	0,775	11	0.5	0,100	16	0,985	25	..	..	
28 Чех	0,861	0,813	9	5.5	0,087	13	0,969	49	..	..	
29 Грек	0,853	0,762	0	10.5	0,146	27	0,959	69	..	..	
30 Бруней Даруссалам	0,852	..	..	..	..	..	0,981	31	..	..	
31 Катар	0,851	..	..	..	0,524	114	0,979	32	..	..	
32 Кипр	0,845	0,752	-3	10.9	0,136	23	0,940	85	..	..	
33 Эстони	0,840	0,767	3	8.5	0,154	29	1,042	70	..	..	
34 Саудын Араб	0,836	..	..	..	0,321	56	0,897	112	..	..	
35 Литва	0,834	0,746	-3	10.4	0,116	21	1,036	58	..	..	
35 Польш	0,834	0,751	-2	9.7	0,139	26	1,010	14	..	..	
37 Андорра	0,830	..	..	..	..	..	..	..	..	..	
37 Словак	0,830	0,778	9	6.2	0,164	32	1,000	1	..	..	
39 Мальт	0,829	0,760	5	8.2	0,220	41	0,954	75	..	..	
40 Арабын НЭУ	0,827	..	..	..	0,244	43	0,958	70	..	..	
41 Чили	0,822	0,661	-16	18.5	0,355	68	0,962	61	..	..	
41 Португал	0,822	0,739	0	9.8	0,116	21	0,970	48	..	..	
43 Унгар	0,818	0,757	7	7.3	0,247	45	0,998	4	..	..	
44 Бахрейн	0,815	..	..	..	0,253	46	0,961	66	..	..	
44 Куба	0,815	..	..	..	0,350	66	0,962	61	..	..	
46 Кувейт	0,814	..	..	..	0,288	50	0,987	22	..	..	
47 Хорват	0,812	0,721	-2	11.1	0,172	33	0,987	22	..	..	
48 Латви	0,810	0,725	0	10.3	0,222	42	1,033	52	..	..	
49 Аргентин	0,808	0,680	-4	15.3	0,381	74	1,001	2	0.015	2005 N	
<b>ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИНДЕКС ӨНДӨР ҮЗҮҮЛЭЛТТЭЙ ОРНУУД</b>											
50 Уругвай	0,790	0,662	-8	15.7	0,364	70	1,015	25	..	..	
51 Багам	0,789	0,676	-3	14.0	0,316	53	..	..	..	..	
51 Монтенегро	0,789	0,733	5	7.1	..	..	..	..	0,012	2005/2006 M	
53 Беларус	0,786	0,726	6	7.5	0,152	28	1,021	32	0.001	2005M	
54 Румын	0,785	0,702	4	10.4	0,320	54	0,973	43	..	..	
55 Ливи	0,784	..	..	..	0,215	40	0,931	93	..	..	
56 Оман	0,783	..	..	..	0,348	64	..	..	..	..	
57 ОХУ	0,778	0,685	3	11.6	0,314	52	1,038	61	..	..	
58 Болгар	0,777	0,692	5	10.8	0,207	38	0,994	8	..	..	



	Хүний Хөгжлийн Индекс	Тэгш бус байдлыг тооцсон ХХИ		Тэгш бус байдлын коэфф	Жендэрийн тэгш бус байдлын индекс		Жендэрийн хөгжлийн индекс		Олон хэмжүүрт ядуурлын индекс	
	Утга	Утга	ХХИ-ийн зэрэглэл		Утга	Рейтинг	Утга	Рейтинг	Утга	Утга <sup>c</sup> судалгаа <sup>d</sup> хийсэн он
ХХИ-ийн рейтинг	2013	2013	2013 <sup>a</sup>	2013	2013	2013	2013	2013 <sup>b</sup>	Утга	Утга <sup>c</sup> судалгаа <sup>d</sup> хийсэн он
59 Барбадос	0,776	..	..	..	0,350	66	1,021	32	..	..
60 Палау	0,775	..	..	..	..	..	..	..	..	..
61 Антигуа ба Барбуда	0,774	..	..	..	..	..	..	..	..	..
62 Малайз	0,773	..	..	..	0,210	39	0,935	91	..	..
63 Мауритиус	0,771	0,662	-2	14.1	0,375	72	0,957	72	..	..
64 Тринидад ба Тобаго	0,766	0,649	-6	15.0	0,321	56	0,994	8	0,007	2006 M
65 Ливан	0,765	0,606	-17	20.3	0,413	80	0,900	110	..	..
65 Панам	0,765	0,596	-18	21.4	0,506	107	0,978	36	..	..
67 Венесуэл	0,764	0,613	-10	19.4	0,464	96	0,999	2	..	..
68 Коста Рика	0,763	0,611	-11	19.1	0,344	63	0,973	43	..	..
69 Турк	0,759	0,639	-3	15.6	0,360	69	0,884	118	..	..
70 Казахстан	0,757	0,667	9	11.8	0,323	59	1,015	25	0,004	2010/2011 M
71 Мексик	0,756	0,583	-13	22.3	0,376	73	0,940	85	0,024	2012 N
71 Сейшелийн Арлууд	0,756	..	..	..	..	..	..	..	..	..
73 Сент-Китс ба Невис	0,750	..	..	..	..	..	..	..	..	..
73 Шри Ланка	0,750	0,643	1	14.2	0,383	75	0,961	66	..	..
75 Иран (Исламын БНУ)	0,749	0,498	-34	32.1	0,510	109	0,847	128	..	..
76 Азербайжан	0,747	0,659	7	11.5	0,340	62	0,952	77	0,009	2006D
77 Иордан	0,745	0,607	-5	18.5	0,488	101	0,842	130	0,004	2009D
77 Серб	0,745	0,663	12	10.9	..	..	..	..	0,001	2010 M
79 Бразил	0,744	0,542	-16	26.3	0,441	85	..	..	0,012	2012N
79 Гүрж	0,744	0,636	4	14.0	..	..	0,941	84	0,008	2005M
79 Гренада	0,744	..	..	..	..	..	..	..	..	..
82 Перу	0,737	0,562	-9	23.4	0,387	77	0,957	72	0,043	2012D
83 Украйин	0,734	0,667	18	9.1	0,326	61	1,012	21	0,002	2007 D
84 Белиз	0,732	..	..	..	0,435	84	0,963	60	0,030	2011 M
84 Македон (хуучин Югославын БН)	0,732	0,633	7	13.3	0,162	31	0,944	83	0,007	2011M
86 Босни-Герцеговин	0,731	0,651	13	10.7	0,201	36	..	..	0,006	2011/2012M
87 Армен	0,730	0,655	15	10.2	0,325	60	0,994	8	0,002	2010D
88 Фижи	0,724	0,613	6	15.1	..	..	0,937	89	..	..
89 Тайланд	0,722	0,573	-2	20.0	0,364	70	0,990	14	0,004	2005/2006M
90 Тунис	0,721	..	..	..	0,265	48	0,891	116	0,006	2011/2012M
91 Хятад	0,719	..	..	..	0,202	37	0,939	88	0,026	2009 N
91 Сент Винсент ба Гренадин	0,719	..	..	..	..	..	..	..	..	..
93 Алжир	0,717	..	..	..	0,425	81	0,843	129	..	..
93 Доминик	0,717	..	..	..	..	..	..	..	..	..
95 Албани	0,716	0,620	11	13.4	0,245	44	0,957	72	0,005	2008/2009D
96 Ямайка	0,715	0,579	1	18.6	0,457	88	0,989	17	..	..
97 Сент Люси	0,714	..	..	..	..	..	..	..	..	..
98 Колумб	0,711	0,521	-10	25.7	0,460	92	0,972	46	0,032	2010M
98 Эквадор	0,711	0,549	-3	22.4	0,429	82	..	..	..	..
100 Суринам	0,705	0,534	-6	23.5	0,463	95	0,974	41	0,033	2010 M
100 Тонга	0,705	..	..	..	0,458	90	0,966	54	..	..
102 Доминиканы БНУ	0,700	0,535	-4	23.4	0,505	105	..	..	0,026	2007D
<b>ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИНДЕКС ДУНД ЗЭРЭГ ҮЗҮҮЛЭЛТТЭЙ ОРНУУД</b>										
103 Мальдив	0,698	0,521	-7	24.2	0,283	49	0,936	90	0,008	2009D
103 Монгол	0,698	0,618	16	11.4	0,320	54	1,021	32	0,077	2005 M
103 Туркменистан	0,698	..	..	..	..	..	..	..	..	..
106 Самоа	0,694	..	..	..	0,517	111	0,948	81	..	..
107 Палестин	0,686	0,606	13	11.7	..	..	0,974	41	0,007	2006/2007N
108 Индонези	0,684	0,553	5	19.1	0,500	103	0,923	98	0,024	2012D
109 Ботсван	0,683	0,422	-21	36.5	0,486	100	0,964	58	..	..
110 Египет	0,682	0,518	-5	22.8	0,580	128	0,855	125	0,036	2008D
111 Парагвай	0,676	0,513	-5	23.7	0,457	88	0,966	54	..	..
112 Габон	0,674	0,512	-5	24.0	0,508	108	..	..	0,073	2012D
113 Боливи	0,667	0,470	-10	29.4	0,472	97	0,931	93	0,097	2008 D
114 Молдав (БНУ)	0,663	0,582	16	12.0	0,302	51	0,990	14	0,005	2005 D
115 Эль Сальвадор	0,662	0,485	-7	26.2	0,441	85	0,965	56	..	..

	Хүний Хөгжлийн Индекс	Тэгш бус байдлыг тооцсон ХХИ		Тэгш бус байдлын коэфф	Жендэрийн тэгш бус байдлын индекс		Жендэрийн хөгжлийн индекс		Олон хэмжүүрт ядуурлын индекс	
	Утга	Утга	ХХИ-ийн зэрэглэл		Утга	Рейтинг	Утга	Рейтинг	Утга	Утга <sup>а</sup> судалгаа <sup>д</sup> хийсэн он
<b>ХХИ-ийн рейтинг</b>	2013	2013	2013 <sup>а</sup>	2013	2013	2013	2013	2013 <sup>б</sup>	Утга	Утга <sup>а</sup> судалгаа <sup>д</sup> хийсэн он
116 Узбекистан	0,661	0,556	14	15.3	..	..	0,945	82	0,013	2006М
117 Филиппин	0,660	0,540	10	18.0	0,406	78	0,989	17	0,038	2008D
118 Өмнөд Африк	0,658	..	..	..	0,461	94	..	..	0,041	2012N
118 Арабын БН Сири Улс	0,658	0,518	4	20.8	0,556	124	0,851	127	0,024	2006 М
120 Ирак	0,642	0,505	0	21.2	..	..	0,802	137	0,052	2011М
121 Гайана	0,638	0,522	10	18.0	0,524	113	0,985	25	0,031	2009 D
121 Вьетнам	0,638	0,543	15	14.9	0,322	58	..	..	0,026	2010/2011М
123 Кабо-Верде	0,636	0,511	4	19.4	..	..	..	..	..	..
124 Микронези (Холбооны Улс)	0,630	..	..	..	..	..	..	..	..	..
125 Гватемал	0,628	0,422	-8	32.0	0,523	112	0,910	104	..	..
125 Киргизстан	0,628	0,519	10	16.9	0,348	64	0,976	39	0,013	2005/2006М
127 Намиби	0,624	0,352	-22	39.3	0,450	87	0,978	36	0,200	2006/2007D
128 Зүүн Тимор	0,620	0,430	-3	29.4	..	..	0,875	122	0,322	2009/2010D
129 Гондурас	0,617	0,418	-6	31.1	0,482	99	0,929	95	0,098	2011/2012D
129 Марокко	0,617	0,433	0	28.5	0,460	92	0,828	132	..	..
131 БН Вануату улс	0,616	..	..	..	..	..	0,900	110	0,135	2007 М
132 Никарагуа	0,614	0,452	4	25.8	0,458	90	0,912	102	0,088	2011/2012 N
133 Кирибати	0,607	0,416	-4	30.1	..	..	..	..	..	..
133 Тажикистан	0,607	0,491	9	18.8	0,383	75	0,952	77	0,031	2012D
135 Энэтхэг	0,586	0,418	0	27.7	..	..	0,828	132	0,282	2005/2006 D
136 Бутан	0,584	0,465	9	20.2	0,495	102	..	..	0,128	2010 М
136 Камбож	0,584	0,440	7	24.6	0,505	105	0,909	105	0,211	2010 D
138 Гана	0,573	0,394	-1	31.2	0,549	122	0,884	118	0,144	2011М
139 Лаос (БНА Улс)	0,569	0,430	8	24.1	0,534	118	0,897	112	0,186	2011/2012 М
140 Конго	0,564	0,391	0	30.6	0,617	133	0,928	96	0,192	2011/2012D
141 Замби	0,561	0,365	-4	34.5	0,617	133	0,913	101	0,318	2007 D
142 Бангладеш	0,558	0,396	4	28.7	0,529	115	0,908	107	0,237	2011 D
142 Сан-Томе ба Принсипи	0,558	0,384	0	30.4	..	..	0,894	115	0,217	2008/2009 D
144 Экваторын Гвиней	0,556	..	..	..	..	..	..	..	..	..
<b>ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИНДЕКС ДООГУУР ҮЗҮҮЛЭЛТТЭЙ ОРНУУД</b>										
145 Балба	2012 D	0,384	3	27.8	0,479	98	0,912	102	0,197	2011 D
146 Пакистан	0,537	0,375	2	28.7	0,563	126	0,750	145	0,237	2012/2013 D
147 Кени	0,535	0,360	0	32.7	0,548	121	0,908	107	0,226	2008/2009 D
148 Свазиленд	0,530	0,354	-2	33.1	0,529	115	0,877	121	0,113	2010 М
149 Ангол	0,526	0,295	-17	43.6	..	..	..	..	..	..
150 Мьянмар	0,524	..	..	..	0,430	83	..	..	..	..
151 Руанда	0,506	0,338	-4	33.1	0,410	79	0,950	80	0,352	2010 D
152 Камерун	0,504	0,339	-2	32.4	0,622	136	0,872	123	0,260	2011 D
152 Нигери	0,504	0,300	-14	40.2	..	..	0,839	131	0,239	2011 М
154 Йемен	0,500	0,336	-2	31.7	0,733	149	0,738	146	0,191	2006 М
155 Мадагаскар	0,498	0,346	2	30.3	..	..	0,917	99	0,420	2008/2009 D
156 Зимбабве	0,492	0,358	7	26.8	0,516	110	0,909	105	0,181	2010/2011 D
157 Папуа Шинэ Гвиней	0,491	..	..	..	0,617	133	..	..	..	..
157 Соломоны Арлууд	0,491	0,374	11	23.8	..	..	..	..	..	..
159 Комор	0,488	..	..	..	..	..	..	..	..	..
159 Танзани (Нэгдсэн БНУлс)	0,488	0,356	8	26.9	0,553	123	0,916	100	0,335	2010 D
161 Мавритани	0,487	0,315	-2	34.6	0,644	140	0,801	138	0,362	2007 М
162 Лесото	0,486	0,313	-2	34.9	0,557	125	0,973	43	0,227	2009 D
163 Сенегал	0,485	0,326	3	32.3	0,537	119	0,864	124	0,390	2010/2011 D
164 Уганда	0,484	0,335	5	30.8	0,529	115	0,896	114	0,359	2011 D
165 Бенин	0,476	0,311	0	34.2	0,614	132	0,822	134	0,401	2006 D
166 Судан	0,473	..	..	..	0,628	138	..	..	..	..
166 Того	0,473	0,317	4	32.6	0,579	127	0,803	136	0,260	2010 М
168 Гайти	0,471	0,285	-3	38.9	0,599	130	..	..	0,242	2012 D
169 Афганистан	0,468	0,321	7	30.0	0,705	147	0,602	148	0,293	2010/2011 М
170 Жибути	0,467	0,306	2	33.7	..	..	..	..	0,127	2006 М



	Хүний Хөгжлийн Индекс	Тэгш бус байдлыг тооцсон ХХИ		Тэгш бус байдлын коэфф	Жендэрийн тэгш бус байдлын индекс		Жендэрийн хөгжлийн индекс		Олон хэмжүүрт ядуурлын индекс	
	Утга	Утга	ХХИ-ийн зэрэглэл		Утга	Рейтинг	Утга	Рейтинг	Утга	Утга <sup>c</sup> судалгаа <sup>d</sup> хийсэн он
<b>ХХИ-ийн рейтинг</b>	2013	2013	2013 <sup>a</sup>	2013	2013	2013	2013	2013 <sup>b</sup>	Утга	
171 Кот д'Ивуар (Зааны ясан эргийн улс)	0,452	0,279	-2	37.9	0,645	141	..	..	0,307	2011/2012 D
172 Гамби	0,441	..	..	..	0,624	137	..	..	0,329	2005/2006 M
173 Этиоп	0,435	0,307	5	28.0	0,547	120	0,853	126	0,537	2011 D
174 Малави	0,414	0,282	1	31.6	0,591	129	0,891	116	0,332	2010 D
175 Либери	0,412	0,273	-1	32.8	0,655	143	0,786	140	0,459	2007D
176 Мали	0,407	..	..	..	0,673	145	0,771	143	0,533	2006 D
177 Гвиней-Бисау	0,396	0,239	-4	39.4	..	..	..	..	0,495	2006 M
178 Мозамбик	0,393	0,277	2	28.9	0,657	144	0,879	120	0,390	2011 D
179 Гвиней	0,392	0,243	-1	37.8	..	..	0,785	141	0,548	2005 D
180 Бурунди	0,389	0,257	2	32.6	0,501	104	0,904	109	0,442	2010 D
181 Буркина Фасо	0,388	0,252	2	34.6	0,607	131	0,924	97	0,508	2010 D
182 Эритрей	0,381	..	..	..	..	..	..	..	..	..
183 Сьерра Леоне	0,374	0,208	-3	43.6	0,643	139	0,799	139	0,405	2010 M
184 Чад	0,372	0,232	1	36.8	0,707	148	0,762	144	..	..
185 Төв Африкийн БН Улс	0,341	0,203	-2	39.9	0,654	142	0,776	142	0,424	2010 M
186 Конго Улс (БН Ардчилсан)	0,338	0,211	1	36.8	..	..	0,822	134	0,399	2010 M
187 Нигер	0,337	0,228	3	31.8	0,674	146	0,714	147	0,584	2012 D
<b>Бусад улс орон, нутаг дэвсгэрүүд</b>										
Солонгос, (БНАСАУ)	..	..	..	..	..	..	..	..	..	..
Маршаллын арлууд	..	..	..	..	..	..	..	..	..	..
Монако	..	..	..	..	..	..	..	..	..	..
Науру	..	..	..	..	..	..	..	..	..	..
Сан-Марино	..	..	..	..	..	..	..	..	..	..
Сомали	..	..	..	..	..	..	..	..	0.500	2006 M
Өмнөд Судан	..	..	..	..	..	..	..	..	..	..
Тувалу	..	..	..	..	..	..	..	..	..	..
<b>Хүний хөгжлийн индексийн бүлэг</b>										
Хүний хөгжлийн индекс маш өндөр	0,890	0,780	-	12.0	0,197	-	0,975	-	-	-
Хүний хөгжлийн индекс өндөр	0,735	0,590	-	19.3	0,315	-	0,946	-	-	-
Хүний хөгжлийн индекс дунд зэрэг	0,614	0,457	-	25.2	0,502	-	0,875	-	-	-
Хүний хөгжлийн индекс доогуур	0,493	0,332	-	32.4	0,586	-	0,834	-	-	-
<b>Бүс нутгууд</b>										
Арабын улс орнууд	0,682	0,512	-	24.2	0,545	-	0,866	-	-	-
Зүүн Ази, Номхон далайн орнууд	0,703	0,564	-	19.5	0,331	-	0,943	-	-	-
Европ болон Төв Ази	0,738	0,639	-	13.2	0,317	-	0,938	-	-	-
Латин Америк, Карибын тэнгис	0,740	0,559	-	23.9	0,416	-	0,963	-	-	-
Өмнөд Ази	0,588	0,419	-	28.0	0,531	-	0,830	-	-	-
Сахарын Африк	0,502	0,334	-	33.5	0,575	-	0,867	-	-	-
<b>Нэн буурай хөгжилтэй орнууд</b>	0,487	0,336	-	30.9	0,568	-	0,859	-	-	-
<b>Хөгжиж буй арлын жижиг орнууд</b>	0,665	0,497	-	24.9	0,478	-	..	-	-	-
<b>Дэлхийн дундаж</b>	0,702	0,541	-	22.8	0,449	-	0,920	-	-	-

**Тайлбар:**

- А** Тэгш бус байдлыг харгалзан ХХИ тооцсон орнууд тээр тулгуурласан
- Б** Улс орнуудыг ХХИ дэх жендэрийн тэнцвэрт байдлын үнэмлэхүй хазайлтаар эрэмбэлсэн
- В** Шинэчилсэн Олон хэмжүүрт ядуурлын индексн Техникийн тэмдэглэл 5 (<http://hdr.undp.org>)-д заасан эрүүл мэнд, боловсрол, стандарт гэсэн 3 хэмжүүрээр доройтлын шинэчилсэн багц тодорхойлолт дээр суурилсан. Бүх улс орнуудын бүх үзүүлэлтүүдийг оруулах боломжгүй байсан тул улс орнуудыг харьцуулахдаа болгоомжтой байх хэрэгтэй. Мэдээлэл байхгүй тохиолдолд, шалгуур үзүүлэлтийн эзлэх жин 100 хувь байна.
- Г** D нь мэдээллийг Хүн ам зүй болон Эрүүл мэндийн судалгаанаас авсныг, M нь мэдээллийг олон өгөгдөл түүвэр судалгаанаас авсныг нь өгөгдлийг үндэсний судалгаанаас авсныг тус тус илтгэнэ.
- Д** Тухайн улс орны зөвхөн хот суурин газрын хэсэгт хамааралтай.
- Е** Хүүхдийн эндэгдлийн үзүүлэлт байхгүй
- Ё** Хоол тэжээлийн үзүүлэлтүүд байхгүй
- Ж** Улс орны зөвхөн нэг хэсгийг илэрхийлнэ

(есөн муж). Суурь төрлийн үзүүлэлт байхгүй

- З** Түлшний үзүүлэлт байхгүй
- И** Сургуульд хамрагдалтын үзүүлэлт байхгүй
- К** Цахилгаан эрчим хүчний үзүүлэлт байхгүй.

**Эх сурвалж:**

**Багана 1:** ХХИГ-ын тооцоолол нь UNDESA (2013a), Варго болон Ли (2013), ЮНЕСКО-гийн статистикийн институт (2013), НҮБ-ын Статистик Хэлтэс (2014), Дэлхийн Банк (2014), ОУВС-гийн (2014) мэдээлэлд тулгуурласан

**Багана 2:** ХХИГ-ын тооцоолол 1-р баганын мэдээлэл дээр үндэслэсэн бөгөөд хүлээгдэж буй амьдралын урт, сургуулийн жил, орлого, хэрэглээ зэргийн тархацын тэгш бус байдлыг Техникийн тайлбар 2-т тайлбарласан (<http://hdr.undp.org>-оос авах боломжтой).

Багана 3: 2 дахь баганын өгөгдөл үндэслэсэн бөгөөд улс орнуудын ХХИ-ийг шинэчлэн эрэмбэлэхдээ Тэгш бус байдлыг харгалзан ХХИ –ийг тооцсон.

**Багана 4:** Техникийн тайлбар 2-т тайлбарласнаар ХХИ-ийн гурван хэмжүүрээр тэгш бус байдлын арифметик дундаж гэж тооцоолсон

(<http://hdr.undp.org>-оос авах боломжтой)

**Багана 5:** ХХИГ-ын тооцоолол нь ДЭМБ-ын болон бусад (2013), UNDESA (2013a), IPU (2013), Варгоба Ли (2013), ЮНЕСКО-гийн Статистикийн Институт (2013), ОУХБ-ын (2013a) судалгаан дээр тулгуурласан,

**Багана 6:** Багана 5-дахь мэдээлэл дээр үндэслэн тооцоолсон.

**Багана 7:** ХХИГ-ын тооцоолол UNDESA (2013a), Варго болон Ли (2013), НҮБ-ын Статистикийн хэлтэс (2014), ЮНЕСКО-гийн Статистикийн хүрээлэн (2013b), Дэлхийн Банк (2014), ОУХБ (2014)-аас авсан мэдээлэл дээр үндэслэсэн.

**Багана 8:** Багана 7 дахь мэдээлэл дээр үндэслэн тооцоолсон.

**Багана 9, 10:** ICF-ийн Хүн ам зүйн болон эрүүл мэндийн макро судалгаа (ХАЗЭМС), НҮБ-ын Хүүхдийн сангийн Олон хэмжүүрт бүлгийн түүвэр судалгаа (ОХБТС) болон зарим тохиолдолд ХАЗЭМС, эсвэл ОХБТС аргачлалаар хийгдсэн үндэсний өрхийн судалгаан дээр үндэслэсэн байна.

**ДЭЛХИЙН ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИЛТГЭЛҮҮД:** 2014 оны Хүний хөгжлийн илтгэл нь 1990 оноос эхлэн жил бүр хөгжлийн асуудлууд, чиг хандлага, ахиц дэвшил болон бодлого хөтөлбөрт сэтгэлгээний хувьд бие даасан, туршлага дээр тулгуурласан үндэслэлтэй дүн шинжилгээ хийх зорилгоор НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрөөс санаачлан боловсруулж, хэвлүүлж эхэлсэн илтгэлүүдийн цуврал болж байна.

2014 оны Хүний хөгжлийн илтгэлтэй холбоотой эх сурвалжууд, нэмэлт материалууд, илтгэлийн хураангуй болон бүрэн хувилбарууд, бусад мэдээллийг 20 гаруй хэл дээр [hdr.undp.org](http://hdr.undp.org) цахим хуудаснаас авах боломжтой. Түүнчлэн 2014 оны илтгэлд зориулсан судалгааны ажлын цувралууд, баримт мэдээллийн цуглуулга, үндэсний хүний хөгжлийн индексийн үзүүлэлтүүд, мэдээллийн сан, интерактив зураг зураглалууд, илтгэлийн хүний хөгжлийн индекст ашигласан эх сурвалжууд, аргачлалуудын дэлгэрэнгүй тайлбар, улс орнуудын танилцуулга, бусад сурвалж материалууд бий. Өмнөх жилүүдэд хэвлэгдсэн дэлхийн болон бүс нутаг, үндэсний Хүний хөгжлийн илтгэлүүд (ХХИЛ) -ийг [hdr.undp.org](http://hdr.undp.org)-аас авах боломжтой.

**БҮС НУТГИЙН ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИЛТГЭЛҮҮД:** Өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд НҮБ-ын бүс нутгийн товчоодын дэмжлэгтэйгээр бүс нутгийн хөгжлийн бүхий л гол асуудлуудыг хамарсан Хүний хөгжлийн илтгэлүүд боловсруулагдан хэвлэгджээ. Эдгээр илтгэлүүд бүсийн хэмжээнд тулгамдаж буй чухал асуудлууд, тухайлбал, Арабын улс орнууд дахь улс төрийн чадавхижуулалт, Африк дахь хүнсний аюулгүй байдал, Ази дахь уур амьсгалын өөрчлөлт, Төв Европ дахь үндэстний цөөнхийн асуудлууд, Латин Америк болон Карибын тэнгисийн орнууд дахь тэгш бүс байдалтай холбоотой бэрхшээлүүд, иргэдийн аюулгүй байдал зэргийг хөндөж, хурц дүн шинжилгээ хийсэн бөгөөд бодлогод нөлөөлөх тодорхой зөвлөмжүүдийг гаргаж танилцуулсан.

**ҮНДЭСНИЙ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИЛТГЭЛҮҮД:** Анх 1992 онд Хүний хөгжлийн үндэсний хэмжээний илтгэл хэвлэгдэн гарснаас хойш дэлхийн 140 гаруй оронд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэй дотоодын зөвлөх, судлаачдын багийн оролцоотойгоор үндэсний хүний хөгжлийн илтгэлүүд хэвлэгдэн гарчээ. Одоогийн байдлаар 700 гаруйд хүрээд байгаа эдгээр илтгэл улс орны дотоодод зохион байгуулагдах зөвлөлдөх уулзалт, судалгааны үр дүнд хүний хөгжлийн үзэл баримтлалыг үндэсний хэмжээний бодлогод тусгахад зөвлөмж болгосон байна. Хүний хөгжлийн үндэсний илтгэлүүд нь уур амьсгалын өөрчлөлтөөс эхлээд залуучуудын ажил хөдөлмөр эрхлэлт, жендэр болон угсаатан ястны асуудлаас үүдэлтэй тэгш бүс байдал хүртэл хөгжлийн олон чухал асуудлыг хөнддөг.

#### ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИЛТГЭЛҮҮД:1990-2014

1990	Хүний хөгжлийн үзэл баримтлал ба хэмжигдэхүүн
1991	Хүний хөгжлийн санхүүжилт
1992	Хүний хөгжлийн дэлхийн хэмжээний цар хүрээ
1993	Хүмүүсийн оролцоо
1994	Хүний аюулгүй байдлын шинэ хэмжүүрүүд
1995	Жендэр ба Хүний хөгжил
1996	Эдийн засгийн өсөлт ба Хүний хөгжил
1997	Ядуурлыг бууруулахад чиглэсэн Хүний хөгжил
1998	Хүний хөгжлийн хэрэглээ
1999	Хүн төрөлхтний төрхтэй даяарчлал
2000	Хүний эрх ба Хүний хөгжил
2001	Хүний хөгжлийн төлөө шинэ дэвшилтэт технологийг ажилладаг болгох нь
2002	Хуваагдмал дэлхий ертөнцөд ардчиллыг гүнзгийрүүлэх нь
2003	Мянганы хөгжлийн зорилтууд: Улс үндэстэн хоорондын нягтрал ба Хүн төрөлхтний ядуурлын төгсгөл
2004	Өнөөдрийн олон янзын ялгаатай байдал оршин буй дэлхийн соёлын эрх чөлөөний асуудал
2005	Олон улсын хамтын ажиллагаа салаа замын үүлзварт: Дэлхийн тэгш бүс тусламж, худалдаа ба аюулгүй байдал
2006	Хомсдлын цаана: Эрх мэдэл, ядуурал, дэлхийн усны хямрал
2007/2008	Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх нь: Хуваагдсан ертөнц дэх хүний эв нэгдэл
2009	Бэрхшээл саадыг даван туулах нь: Хүний шилжилт хөдөлгөөн ба хөгжил
2010	Үндэстний жинхэнэ баялаг: Хүний хөгжилд хөтлөх арга замууд
2011	Тогтвортой хөгжил ба эрх тэгш байдал: Бүх нийтийн сайн сайхан ирээдүй
2013	Өмнөдийн сэргэлт: Улс орнуудын хүний хөгжилд гарч буй ахиц дэвшил
2014	Хүний ахиц дэвшлийг тогтворжуулах: Эмзэг байдлыг бууруулж, даван туулах чадварыг бий болгох нь



Жилд 200 гаруй сая хүн, тэднээс ихэнх нь хөгжиж буй орнуудад байгалийн гамшигт өртөж байна. 2012 оны эцсийн байдлаар зөрчил, мөргөлдөөн, хавчлага мөрдлөгийн улмаас сүүлийн 18 жилд хамгийн их буюу 45 сая хүн оршин суугаа газраа орхин дүрвэхэд хүрсэн байна. Эдийн засгийн уналт аж үйлдвэржсэн хөгжингүй оронд ч нийгмийн ололтуудыг үгүйсгэхээр заналхийлэх боллоо. Даяаршил нь олон олон ашиг тусыг хүн төрөлхтөнд авчрахын зэрэгцээ шинэ шинэ эмзэг байдлыг бас дагуулж байна. Дэлхийн нэг хэсэгт учирсан гамшиг асар хурдан тархаж хаа сайгүй хүмүүсийн амьдралд нөлөөлдөг болжээ.

Илтгэл ард түмний сонголтыг дэмжихийн зэрэгцээ хүний хөгжлийн ололт амжилтын хамгаалах хэрэгтэйг онцлон сануулж байна. Түүнчлэн санхүүгийн, байгалийн, эсвэл өөр ямар ч аргаар бай, иргэдэд гэнэтийн осол гамшигийг даван туулах чадварыг бий болгож, цочролд дасан зохицох чадавхийг нь сайжруулах замаар амь бөхтэй оршсоор байгаа эмзэг асуудлуудыг тодорхойлохын ач холбогдлыг чухалчлан тавьж байна. Бараг хүн бүр амьдралынхаа аль нэг мөчид эмзэг байгаагаа мэддэг ч зарим хувь хүн, бүлэг хүмүүс байнгын хүнд нөхцөлд оршиж байна. Бараг 1.5 тэрбум хүн олон хэмжүүрээр нэн ядуу, эрүүл мэнд, боловсрол, амьжиргааны наад захын стандартын давхардсан хомсдолд амьдарч байна. Мөн 800 орчим сая хүн

хямрал нүүрлэхэд ядуурлын ангал руу унахад маш ойрхон, эмзэг нөхцөлд байна. Илтгэл хамгийн их эрсдэлд байгаа хүмүүс болон эмзэг байдал руу хөтөлж байгаа цаад шалтгаануудад түлхүү анхаарсан болно.

Энд нийгэмд оршин буй тусгаарлал, ялгаварлал, байр суурь, нийгмийн үйлчилгээний хомсдол зэрэг бүтцийн шалтгааныг задлан шинжилж, хүний амьдралын мөчлөгийн янз бүрийн үе шатанд тулгардаг төрөл бүрийн эмзэг байдалд анхаарал хандуулж байна.

Хор хөнөөл болон эрсдэл цочрол тохиолдох нь зайлшгүй боловч эдгээр үйл явдал хүний хөгжлийг хир хэмжээгээр бууруулахыг тооцох хэмжүүр гаргаж, эсрэг арга хэмжээ авч болно. Зөв бодлого, нийгмийн хүчтэй эв нэгдлийг хангаснаар ямар ч цочрол, хямралыг даван гарч болохыг Илтгэл онцолж байна. Эрт илрүүлэх механизм, зөв цагт оруулсан их биш хөрөнгө оруулалтаар эмзэг байдлыг бууруулж, гамшигийг даван туулах чадварыг бий болгох боломжтой юм. Эмзэг байдал, даван туулах чадварыг нэгтгэсэндүн шинжилгээгүй бол хүний хөгжлийн хандлага бүрэн бус болно. Хүн амын эмзэг бүлгийг тодорхойлж анхааралдаа авах, тэгш бус байдлыг бууруулах, бүтцийн эмзэг асуудлыг шийдвэрлэх нь хүний хөгжил, ахиц дэвшлийг үе дамжуулан тогтворжуулахад чухал ач холбогдолтой.

*“Эмзэг байдлыг шийдвэрлэснээр бүх хүн хөгжлийн ахиц дэвшлийг олж, хүний хөгжил улам бүр тэгш, тогтвортой байх болно.”*

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Захирагч Хелен Кларк

*“Эмзэг байдал нь олон шалтгаан, үр дагавартай байдаг. Эмзэг байдлыг бууруулах нь хүний хөгжлийг сайжруулах ажлын гол бүрэлдэхүүн хэсэг юм. Бид эмзэг байдлыг бууруулахад амжилт олж эгвэл системтэй өргөнөөр хандах хэрэгтэй”.*

Нобелийн шагналт Жозеф Штиглиц 4-р бүлэг

*“Хүний даван туулах чадвар гэдэг нь аливаа саад тотгорыг арилгаж, тэднийг ажиллах эрх чөлөөгөөр хангах тухай асуудал юм. Мөн ялгаварлан гадуурхагдсан хүмүүсийг санаа бодлоо илэрхийлж, бусдад сонсогдох, хувь заяаныхаа идэвхтэй эзэд нь байхад чадваржуулах асуудал юм”.*

Илтгэлийн үндсэн зохиогч Халид Малик, 1-р бүлгээс

*“Олон төрлийн, агуу ахиц дэвшил байгаа хэдий ч ядуу эмзэг иргэд, эмзэг бүлгүүд байсаар байна. Тэдний хэн нь ч цаашид ийм бэрхшээлд байж болохгүй. Нэгдсэн Үндэстний Байгууллагын тооцоолсноор нэг тэрбум гаруй хүн ямар нэг хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй амьдарч, тэд дэлхийн хамгийн ядуучуудын дунд харилцан адилгүй тархалттай байна.”*

Профессор Стивен Хокинг, 1-р бүлгээс